

БИ ҮЙЛДВЭРЛЭГЧ

⊖ Багачуудын гоёл “Бүүвэй” брэнд

➔ 14

ЦАГ ҮЕ

⊖ Сүмо тайлбарлагч М.Цолмонбаяр Mitsubishi-г мэхэлсэн үү

➔ 6

ЭКОЛОГИ

⊖ CO2-ыг хуримтлуулан ашиглавал том бизнес болж магадгүй

➔ 19

ZGM DAILY

⊖ FULL ENGLISH PAGE INSIDE

➔ 20-21

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ



2019.12.05, ПҮРЭВ~№210 (1262)

~ ИРГЭН БАЯН БОЛ УЛС БАЯН ~

₮1000, 24 НҮҮР

АЛТ	ЗЭС	ТӨМРИЙН ХҮДЭР	НЕФТЬ	ЧИНГИС БОНД	ХУРАЛДАЙ БОНД	ГЭРЭГЭ БОНД	САМУРАЙ БОНД	АМ.ДОЛЛАР	ЮАНЬ	РУБЛЬ	ВОН
1,482.20 0.15%	5,815.00 1.16%	630.00 1.61%	58.24 0.58%	102.13 0.13%	113.30 0.12%	103.58 0.12%	103.43 0.60%	2719.38	385.91	42.37	2.29



## Дэлхийн хөгжлийн бодлогыг эмэгтэйчүүд тодорхойлж байна

📷 Гэрэл зургийг Ш.Отгонжаргал

✍ Э.Батцэцэг, ЗГМ сонин


Аливаа байгууллагын ТУЗ-ийн гишүүдийн 30-аас доошгүй хувийг эмэгтэй удирдагчаар бүрдүүлвэл зөв засаглалтай, шударга, хүнлэг үйл ажиллагаа

явуулахаас гадна ногдол ашигт хүртэл ахиу мөнгө хуваарилдаг болохыг олон улсын хамаг том гэгдэх судалгааны байгууллагууд нотолсон. Түүнчлэн одоогоос зургаан жилийн өмнө Дэлхийн эдийн засгийн форумд “Эмэгтэй

лидерүүд бизнес, улс төрд олноор орох тусам дэлхий аврагдана” гэж тунхаглаж байлаа. Энэ нь эмэгтэйчүүд олноороо удирдлагыг гартаа авах тусам дэлхийд энх тайван тогтож, энэрэнгүй нийгэм бий болно гэдэгтэй санал нэгдсэн

хэрэг билээ. Fortune сэтгүүлээс жил бүр нэрлэдэг тэргүүлэгч 500 компанийн зургаан хувь буюу 30-ийг нь эмэгтэйчүүд удирдаж байна. Энэ зууны эхэнд уг жагсаалтад ердөө ганцхан эмэгтэй захирал багтаж байлаа. ➔ 4

⊖ Н.Мөнхтуяа: Нөхөр маань футболка зарж, тэмцээний зардлаа олсон ➔ 3



\$100 мянган гэрээ байгуулах боломжид нэг алхам ойртлоо.

⊖ Ипотекийн зах зээл зургаан жилийн дотор 5.3 дахин өсжээ ➔ 8



Ирэх онд ипотекийн хөтөлбөрөөс төв банк гарч, Засгийн газар хэрэгжүүлнэ. Сонгуулийн жил ипотекийн санхүүжилт нэмэгдэх бус эсрэгээрээ хорогдлоо.

⊖ 25 жилийн дараа хүрээд ирсэн аавтайгаа хамт амьдрах нь буруу юу ➔ 13

Охин хүүхэд эцгээ харж хандах ёстой гэсэн эхийнхээ захиасыг санаад гомдож явдаг ч гэсэн хүлцэхээр шийдсэн.

Өнөөдөр	Маргааш
-2°C ☁	-12°C ☁
-13°C 🌙	-15°C 🌙



ХЭР ИХИЙГ УНШИХ НЬ БУС ЮУГ СОНГОЖ УНШИХ НЬ ЧУХАЛ




- НӨХӨРСӨГ ФОРМАТ
- ОЛОН ТАЛЫН МЭДЭЭЛЭЛ
- АЖИЛ ХЭРЭГЧ НИЙТЛЭЛИЙН БОДЛОГО

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН ТАНД ЦОО ШИНЭ ӨНГӨ ТӨРХТЭЙГЭЭР ХҮРЧ ЭХЭЛЛЭЭ

Яг одоо захиал [www.zgm.mn](http://www.zgm.mn) Утас: 70103131

## “Хөгжлийн зам”-д хурд хайрлаач

Налайхын замыг тууш замын ангилалд багтааж хөдөлгөөний хурдыг нэмэх боломжтой



Мелинда Гейтс, Bill & Melinda Gates Foundation-ийн захирал

Хаана төрснөөсөө үл шалтгаалан бүх эмэгтэйчүүд өөрсдийн ирээдүйгээ тодорхойлж чаддаг байх нь чухал. Өөрийн гэсэн дуу хоолойгоо хүргэж чаддаг эмэгтэй бол хүчирхэг эмэгтэй.





## УЛС ТӨР

БАЙНГЫН ХОРОО

## Ирэх оны мөнгөний бодлого эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой

Банкуудын хадгаламжийн хүү өндөр учир зээлийг хүүг шууд бууруулах боломжгүй

Б.Энхжаргал, ЗГМ сонин

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах баримт бичгийг парламентаар хэлэлцэж байна.

Төв банкнаас өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын үндсэн зорилт эдийн засгийн уналтыг зогсоож, богино хугацаанд тогтворжуулах байсныг Ажлын хэсгийнхэн хэлж байна. Гэхдээ 2017 оноос эдийн засаг тогтворжсон учир 2018 оны мөнгөний бодлогын зорилтыг эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглүүлсэн аж. Тухайлбал, бизнесийн зээлийг нэмэх, аж ахуйн нэгжүүдэд зээл олгох зэргийг нэрлэж байв. 2019 онд гадаад эрэлт, түүхий эдийн үнэ гэх мэт өндөр өсөлтийг дэвэргэх биш дунд, урт хугацааны савлагааг багасгах чиглэлээр зорилтуудаа тодорхойлсон. Мөн банкуудыг



Гэрэл зургийг С.Батсайхан

чадавхжуулах чиглэлийн бодлого хэрэгжиж байна хэмээн Төв банкны төлөөлөл хэлсэн юм. Харин 2020 онд эдийн засгийн өсөлтийг дэмжихэд бүрэн чиглэх аж.

Энэ үеэр УИХ-ын гишүүн Б.Баттөмөр зээлийн хүүг бууруулах асуудлыг хөндөв. **Гэхдээ Монголын арилжааны банкуудын хадгаламжийн хүү өндөр учир зээлийн хүүг шууд**

**бууруулах боломжгүй.** Тиймээс салбарын тоглогчидтой хэлэлцэх замаар хадгаламжийн хүүг бууруулах боломж бий эсэхийг тодруулж байгаа.

Хадгаламжийн өндөр хүү зээлийн хүүд нөлөөлж буйг Төв банкныхан ч хүлээн зөвшөөрөв. **Энэ талаар Ажлын хэсэг “Бид эх үүсвэрийн төвлөрөлд хязгаарлалт тавьж, эрсдэл**

**буурвал зээлийн хүүд эерэг нөлөө үзүүлэх болов уу гэж бодож байна. Энэ үүднээс арга хэмжээ авч байгаа юм” гэлээ.**

Ийн хэлэлцсэний эцэст байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай тогтоолын төслийг дэмжлээ. ■

ЗГМ: ТОВЧХОН

■ ТОО

120

Сая шоо метр Монгол Улсын хэмжээнд 130 гаруй цэвэрлэх байгууламж байгаагаас ихэнх нь эвдрэлтэй аж. Цэвэрлэх байгууламжийн доголдлоос жилд 120 сая тонн шоо метр бохир усыг хаяж байна.

■ ШҮҮХ

ЗТХЯ-ны газрын даргын үйлдсэн хүн амины хэргийн шүүх хурлыг маргааш хийхээр товложээ. Энэ оны тавдугаар сарын 17-нд уг хэргийг үйлдэгчийн хэргийн гэм буруугийн шүүх хурал болж, нөхөн гүйцэтгэх боломжгүй нэмэлт ажиллагааг хийх шаардлагатай гэж үзээд хэргийг прокурорт буцаах шийдвэр гаргасан юм. Түүнээс хойш зургаан сар гаруйн дараа нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуульд заасны дагуу яллах дүгнэлт үйлдэж дахин ирүүлжээ.

■ ТӨСӨЛ

ТББХ-ны хуралдаанаар УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг шийдэх ёстой байв. Гэвч гишүүдийн олонх нь төсөлтэй танилцах хугацаа гаргах нь зүйтэй гэдэг санал гаргаснаар хойшлууллаа. ■

АЙЛЧЛАЛ

## Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барихад “РЖД Интернэшнл” тусална

У.Хүрэлсүх, Д.А.Медведев нар 12 баримт бичигт гарын үсэг зурав

Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ОХУ-д хийж байгаа албаны ёсны айлчлалаар талууд харилцаа, хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа.

Цахилгаан эрчим хүч, төмөр зам, нийгмийн хамгаалал, хууль зүй, гадаад харилцаа, хүнс хөдөө аж ахуйн салбар болон “Газпром”, “Роснефть” зэрэг Оросын төрийн мэдлийн томоохон компаниудтай Монголын Засгийн газар хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан байна. Мөн өмнө нь хоёр улсын хооронд өрнүүлсэн зарим хэлэлцээр хүчин төгөлдөр болсныг энэ үеэр зарласан юм.

Тухайлбал, бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай Монголын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр хүчин төгөлдөр болсныг



зарлалаа. Түүнчлэн “Геологи, геофизикийн болон инженер-геологийн судалгааны салбарт хамтран ажиллах тухай “Эрдэнэт үйлдвэр” болон ОХУ-ын “Зарубежгеология” Хувь

Нийлүүлсэн нийгэмлэг хоорондын гэрээ”-г хүчинтэйд зарлаж байна. Мөн “Зүүнбаян-Таван толгойн чиглэлд төмөр замын шугам барих ажил гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхэд техникийн

зөвлөгөөний үйлчилгээ үзүүлэх тухай “Улаанбаатар төмөр зам” Хувь Нийлүүлсэн нийгэмлэг, “РЖД Интернэшнл” хязгаарлагдмал хариуцлагатай нийгэмлэг хоорондын гэрээ”-нд - Монголын талаас Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” ХХН-ийн дарга Д.Жигжиднямаа, Оросын талаас “РЖД Интернэшнл” ХХН-ийн Ерөнхий

захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.А. Столяров нар гарын үсэг зурж, баталгаажууллаа. “Эрдэнэс Монгол” ХХК ба ОХУ-ын “УЗТМ-Картэкс” ХХК УК-ийн Стратегийн түншлэлийн тухай санамж бичиг”, “Арьс ширний бэлтгэн нийлүүлэлт, худалдааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХК болон ОХУ-ын “Русская кожа” хувьцаат нийгэмлэг хоорондын санамж бичиг” зэрэг баримт бичгүүдийг баталгаажуулсан аж.

Түүнчлэн “Хамтын ажиллагааг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Худалдаа, хөгжлийн банк ба ОХУ-ын Оросын экспортын төв хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”-т Монголын талаас Худалдаа, хөгжлийн банкны Ерөнхийлөгч Б.Мэдрээ болон Оросын экспортын төвийн гүйцэтгэх захирал А.Слепнев нар гарын үсэг зурлаа. ■

“ГАЗПРОМ”, “РОСНЕФТЬ” ЗЭРЭГ ОРОСЫН ТӨРИЙН МЭДЛИЙН КОМПАНИУДАЙ МОНГОЛЫН ЗАСГИЙН ГАЗАР ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИЙГ БАЙГУУЛАВ.



# Н.Мөнхтуяа: Нөхөр маань футболка зарж, ТЭМЦЭЭНИЙ зардлаа олсон

\$100 мянган гэрээ байгуулах боломжид нэг алхам ойртлоо

Т.Намуунболор, ЗГМ сонин

**Х**олимог тулааны хэт хөнгөн жингийн тамирчин, Монголын холимог тулааны “MGL-1” холбооны аварга О.Пүрэв болон хагас хүнд жингийн тамирчин Т.Ганбаяр нар Сингапур улсад болж буй One Championship холбооны One Warrior Series-9 тэмцээнд өрсөлдөж, өчигдөр анхны тулаанаа хийлээ. **О.Пүрэв БНСУ-ын тамирчин, Just MMA холбооны аварга Тае Хо Бэкийн эсрэг тулалдаж, гуравдугаар үед боолтоор шууд буулгаж авлаа.** Тэрбээр энэ тулаанд ялснаар One Championship холбоотой 100 мянган ам.долларын гэрээ байгуулах боломжид нэг алхам ойртож буй юм. **Харин Т.Ганбаяр Индонез улсын тамирчин Винсент Мажидийг техникийн нокуатаар буулган авч, One Championship-ийн гараагаа гайхалтай эхлүүлээ.** О.Пүрэвийн эхнэр Ү.Мөнхтуяатай манай сонин холбогдож, сэтгэгдлийг нь асуухад “Нөхрөө ялсанд сэтгэгдэл өндөр байна. Тав дахь өдөр эх орондоо ирнэ. Өөрийн гаргасан футболкоо зарж, олсон орлогоороо тэмцээний зардлаа олсон” хэмээсэн юм. ■



## Анна Каренинаг Монголын тайзнаа амилуулна

Оросын нэрт зохиолч Лев Толстойн бүтээл, дэлхийн сонгодог зохиолын ноён оргилын нэг Анна Каренина гэх гайхамшигт зохиол тун удахгүй жүжиг хэлбэрээр УДЭТ-ын тайзнаа амилах гэж байна. Жүжгийн зохиолыг Н.Пүрэвдагва бичжээ. Одоогоор гол дүрийн жүжигчнээ хараахан сонгоогүй бөгөөд энэ сарын 15 гэхэд монгол Каренинаг хэн амилуулах нь тодорхой болох юм.



Жүжгийн ерөнхий найруулагч Н.Наранбаатартай цөөн хором ярилцлаа.

**-Москва руу жүжгийн судалгаа хийхээр явсан гэсэн. Театрын эх орноос ямар туршлага судлав?**

-Лев Толстойн амьдарч байсан газрыг үзэх хамгийн сонирхолтой байлаа. Москвагаас 300 км зайтай Тульская мужийн Ясная Поляна гэдэг эдлэн газарт очоод ирсэн. Яагаад энэ зохиолыг бичих болсон, Анна Каренина өөрөө бодит хүн байсан уу гэх мэт маш олон эх сурвалж, баримтыг нягтлах зорилготой явсан. Мөн Москвад Анна Каренина мюзиклыг үзэж, театрын соёлоор нь их бахадсан. Орос орон театртаа маш их анхаарал хандуулж, хөрөнгө

мөнгө зарцуулдаг. Нийт 250 гаруй театртай. Дахиад ч нэмж барих гэж байна билээ. Үнэхээр гайхалтай байгаа биз. Хүн төрөлхтөний соёлын түвшин, улс орны хөгжлийн түвшинг театраар нь хэмжиж байна. Тэнд театрын урлаг ямар тансаг, эрхэмсэг оршихуй болох, хүмүүс оюуны цангаагаа хэрхэн тайлж, эргэцүүлж байна гэдгийг яривал маш их зүйл бий.

**-Анна Каренина бол эмэгтэй хүний тухай гайхамшигтай зохиолын нэг. Дэлхийн сонгодог гэдгээс гадна Каренинаг амилуулах болсон өөр шалтгаан бий юу?**

-Нэгдүгээрт, энэ бол хүн төрөлхтөний тэргүүн зэргийн зохиол. Анна Каренинаг бүтээл болгож, олон нийтэд хүргэнэ гэдэг тухайн улс орон, ард түмний оюуны чадавхыг илэрхийлнэ. Оросоос хальж, дэлхийн сонгодог болсон зохиолоор уран бүтээл хийж буй учраас театрын чадвар чансааг ч харуулна. Хоёрдугаарт, Анна Каренина зохиолд гарч байгаа үйл явдал, агуулга нь өнөөдрийн манай нийгмийн төрхтэй нийцэж байгаа юм. Зохиолчийн эмзэглэл нь өнөөгийн цаг үед илэрхийлэх ёстой сэдэв яах аргагүй мөн. Манлайлж, хийж бүтээж яваа хүмүүсээ үгүйсгэдэг, бүхнийг харлуулж сошиалаар "буудаж" байгаа Монголын энэ цаг үе XIX зууны үеийн Оросын нийгэмтэй яг адил байна.

**-Хэзээ нээлтээ хийх вэ?**

-Ирэх хоёрдугаар сарын 27-нд нээлтээ хийхээр төлөвлөж байна. ■

## Асуудал үүсэж байсан эсэхээс үл хамааран бэлгийн дарамтын эсрэг нэгдэх хэрэгтэй

Бэлгийн дарамт гарах эрсдэлтэйг үгүйсгэхгүй



Манай сонин спортын салбар дахь бэлгийн дарамтын эсрэг дуу хоолойгоо нэгтгэхийг уриалж, цуврал нийтлэл болон тамирчид, спортын холбоодын байр суурийг хүргэсээр байгаа билээ. Хамгийн сүүлд Монголын үндэсний уулчдын холбоо манай уриалгад нэгдэж байна. Тус холбооны ерөнхийлөгч Б.Тулгатай ярилцсанаа хүргэе.

**-Спортын салбар дахь бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох уриалгад нэгдсэнд талархал илэрхийлье.**

-Спорт бол хүний эрүүл мэндийн суурь болсон, хамгийн эерэг зорилготой салбар. Тиймээс бэлгийн дарамт, хүчирхийллийн шинжтэй үйлдэл хэрхэвч байж болохгүй. Уулын

спортын хувьд тамирчид болон дасгалжуулагчдын хүйсийн харьцаа тэнцүү, энэ чиглэлд анхаарал хандуулан ажилладаг учраас бэлгийн дарамттай холбоотой асуудал гарч байгаагүйг бардам хэлж чадна. Гэхдээ гарах эрсдэлтэй үгүйсгэхгүй. Тиймээс анхаарал хандуулж, санаачилга гаргаж байгаа бүхий л үйл ажиллагааг дэмжин ажиллах болно. Бусад холбоо ч асуудал гарч байсан эсэхээс үл хамааран нэгдэж, дуу хоолойгоо өргөхийг уриалж байна.

**-Танай холбоо спорт дахь бэлгийн дарамтын эсрэг ямар арга хэмжээ авч байгаа вэ?**

-Олон улсын уулчдын холбоо энэ асуудлаас сэргийлэх чиглэлд анхаарч, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлого баримталдаг. Ажлын байрны орчинд хүйсийн тэгш байдлыг бий болговол энэ төрлийн дарамтаас сэргийлэх боломжтой. Манай холбооны зүгээс удирдах албан тушаал дахь эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр спортын холбоодод сургалт зохион байгуулдаг. ■

**Удирдах түвшин дэх жендэрийн тэгш байдлыг хангах нь бэлгийн дарамтаас сэргийлэх, таслан зогсоох ач холбогдолтой.**



# Дэлхийн хөгжлийн бодлогыг эмэгтэйчүүд тодорхойлж байна

дэлхий нийт эмэгтэй удирдагчдын уян хатан бодлогын ачаар хүнд байдлаас аврагддаг



Эмэгтэйчүүдийн хатан ухаан, удирдах авьяас, чадварыг 2009 оны хямралаас хойш дэлхий нийтээр үнэлж эхэлсэн

## [ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга  
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**  
Ерөнхий эрхлэгч  
**Баатарын Дуламхорлоо**  
Зөвлөх  
**Шатарбалын Даваадорж**  
Орлогч эрхлэгч  
**Лхагважавын Сугармаа**  
Утас: 99903584

### РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба  
Эдитор Б.Энхжаргал  
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба  
Эдитор Г.Баярсайхан  
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

### ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581  
99903578  
99907843

### ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn  
ubinfo.mn

### ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,  
“Блю Скай тауэр” 407 тоот  
Улсын бүртгэлийн дугаар. 1024  
Утас: 70103131,  
Факс: 70106065

### ДУГААРЫН УДИРДАГЧ

**Л.Сугармаа**

### ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» [INFO@ZASAG.CO](mailto:INFO@ZASAG.CO)

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.



Эдийн засгийн хямралын энэ үед АНУ-ын Холбооны нөөцийн банкны тэргүүнээр ажиллаж байсан хатагтай Жанет Иеллений зоригтой шийдвэр, удирдлагын уян хатан чанар тус улсын дэлхийд тэргүүлэгч эдийн засгийг хэвээр хадгалж чадсан юм. Түүнчлэн энэ оны аравдугаар сард ОУВС-гийн тэргүүний ажлаа өгч, Европын Төв банкны ерөнхийлөгчөөр өрсөлдөгчгүй сонгогдсон хатагтай Кристин Лагард хямралын үед Францын Сангийн сайд байхдаа улсынхаа эдийн засгийг тасралтгүй өсгөж, энэ байдлыг хамгийн удаан хадгалж чадсан эмэгтэй.

Дэлхийн эдийн засгийн 25 хувийг бүрдүүлдэг Европын холбоог удирддаг Европын комисс ч анх удаа эмэгтэй хүнийг ерөнхийлөгчөөрөө сонгосон. Өнгөрсөн 11 дүгээр сарын 1-нээс Европын комиссын ерөнхийлөгчийн ажлыг хүлээж авсан Германы Батлан хамгаалахын сайд асан Урсула фон дер Лейен уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Евро бүсийг тэргүүлэгч байр сууринд байлгаж, их хэмжээний хөрөнгө “хаяж”, эх дэлхийгээ хамгаалахаа мэдэгдсэн.

Манай хойд хөршид ч 2013 оноос тус улсын Төв банкны түлхүүрийг Моксвагийн их сургууль, АНУ-ын Иелийн их сургуулийг төгссөн эдийн засагч Эльвира Сахипзадовна Набиуллинад атгуулсан. Барууны орнуудын хориг, газрын тосны ханшийн уналт, валютын нөөцийн хомсдол

**ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН 25 ХУВИЙГ БҮРДҮҮЛДЭГ ЕВРОПЫН ХОЛБООГ УДИРДДАГ ЕВРОПЫН КОМИСС АНХ УДАА ЭМЭГТЭЙ ХҮНИЙГ ЕРӨНХИЙЛӨГ-ЧӨӨРӨӨ СОНГОСОН. ӨНГӨРСӨН 11 ДҮГЭЭР САРЫН НЭГНЭЭС ЕВРОПЫН КОМИССЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЖЛАА ХҮЛЭЭЖ АВСАН ГЕРМАНЫ БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД АСАН УРСУЛА ФОН ДЕР ЛЕЙЕН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ ЕВРО БҮСИЙГ ТЭРГҮҮЛЭГЧ БАЙР СУУРИНД БАЙЛГАЖ, ИХ ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГӨ “ХАЯЖ”, ЭХ ДЭЛХИЙГЭЭ ХАМГААЛАХАА МЭДЭГДСЭН.**

нүүрлэсэн хүнд байдлаас ОХУ-ыг богино хугацаанд гаргаснаас гадна өдгөө тус улс валютын нөөцөөрөө дэлхийд тэргүүлэгчдийн нэг, хүчирхэг

эдийн засгаа хэвээр хадгалж чадаж буй нь нууц хатагтайн удирдахуйн ур ухаантай салшгүй холбоотой.

**Дэлхийн 173 орны төв банкаас 11-ийг нь эмэгтэй ерөнхийлөгч удирддаг бол Энэтхэг, Индонез, Испани зэрэг 30 гаруй улсын Сангийн сайд нь эмэгтэй улстөрч байна.**

Тэгвэл Монгол Улсад ч эмэгтэй удирдагчдын үүрэг, нөлөө ихэссээр буй юм. Энэ удаагийн УИХ-д парламентын түүхэнд анх удаа 17 хувьд нь эмэгтэй төлөөлөл сонгогдсон. Дэлхий нийтээр эмэгтэйчүүдэд удирдлагаа шилжүүлж буй хандлагаас харахад ирэх сонгуулиар энэ үр дүнг ахиулах магадлал бий. Улс төрөөс гадна бизнес эрхлэгчдийн дунд эмэгтэй удирдагчтай компани дунд хүч түрэн орж ирсээр байна. Монголын топ аж ахуйн нэгжийн тэргүүн фронтод тасралтгүй жагсаж ирсэн “Петровис”, “НИК” компанийг удирддаг хатагтай Ж.Оюунгэрэл нэн түрүүнд хүлээн зөвшөөрөгдөх удирдагч юм. Түүний удирддаг компаниудаас олон улсад IPO гаргаж, амжилттай яваа нь ч бий. Мөн Дэлхийн банкинд зөвлөх хүртэл хийж явсан “Голомт” банкны ТУЗ-ийн дарга хатагтай Ч.Мөнхцэцэг салбартаа өрсөлдөхүйц технологи хэрэгжүүлэх алхмыг цаг алдалгүй хийж ирсэн. Түүнчлэн “Таван богд” группийн тэргүүн дэд ерөнхийлөгч Д.Хулан, “Тавантолгой транс” компанийн ТУЗ-ийн дарга Г.Ганчимэг, “Жем интернэйшнл” группийн ТУЗ-ийн дарга Б.Ойгонжаргал, “АПУ трейдинг” компанийн

гүйцэтгэх захирал П.Батчимэг нарын удирдагч эмэгтэй олны өмнө төдийлэн ил гардаггүй ч, удирдаж буй байгууллагынхаа ахиц амжилтаар нэгэнт танигдсан билээ.

Гаднын орнуудад боловсрол эзэмшсэн, олон улсад бизнесээ таниулсан эмэгтэйчүүд Монголын нүүр царай болсоор байгааг хүн бүхэн мэднэ. Улаанбаатар хотын Худалдааны танхимын тэргүүн, “Делоитт онч аудит” ХХК-ийн захирал Д.Ончинсүрэн дотоодын компаниудыг олон улсын түвшинд гаргахад томоохон дэмжлэг үзүүлдэг.

Лидер эмэгтэйчүүдийн хүрээнд шинэ үе түрэн орж ирснийг зайлшгүй тэмдэглүүштэй. 2018 онд МҮХАҮТ-ын зарласан “Топ 100” аж ахуйн нэгжийн жагсаалтын зургадугаарт МАК ХХК-ийн ерөнхийлөгч Н.Цэлмүүн орж ирсэн нь эмэгтэй удирдагчтай хамгийн дээгүүр эрэмбэлэгдсэн компани болов. 10 жилийн өмнө тус компани 31 дүгээрт жагсаж байсан бол өдгөө айргийн тавд багтаж өрсөлдөх

болжээ. Түүнчлэн “Монполимет” группийн ерөнхий захирал Н.Мөнхнасан, “Жигүүр гранд” группийн ерөнхий захирал Б.Халиунаа, “Нано” группийн гүйцэтгэх захирал Б.Бүжинлхам нарын чадварлаг залуу удирдагчдаас Монголын нийгэм үлгэр дуурайл авч, ихийг хүлээж байгаа билээ.

Ийнхүү дэлхий нийтээрээ эмэгтэй удирдагчдын уян хатан бодлогын ачаар хүнд байдлаас аврагдаж, эх дэлхийгээ хайрласан, илүү олон хүнийг тэгш, тогтвортой амьжиргаатай, эрүүл аюулгүй орчинд амьдруулах чин эрмэлзэлд хөтлөгдөх болов. Монгол Улсад ч энэ хандлага шингэж шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо ихсэх тусам нийгмийн зүй бус үзэгдлүүд багасна гэдэгт итгэдэг. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн удирдагч хатагтай Кристин Лагардын

хэлсэн “Байдал дордсон үед эмэгтэйчүүд рүү залга” гэдэг нандин үгийг эрх баригчдад сануулмаар байна. ■

**ЭШЛЭЛ**  
**Эмэгтэй удирдагч нар эх дэлхий, хүн төрөлхтөнд ээлтэй шийдвэр гаргадаг**



**С.ОЮУН**  
*НҮБ-ын Уур амьсгалын ногоон сангийн Гадаад хэрэг хариуцсан захирал*

Уур амьсгалын өөрчлөлт ба жендэрийн асуудалд тодорхой уялдаа холбоо бий. Цаг уурын өөрчлөлт, усны хомсдол зэрэг гамшгийн эсрэг ажиллахад эмэгтэйчүүд илүү сэтгэлтэй ажилладаг байж магад. Усны хомсдлоос үүдэн ган гачиг улам бүр нэмэгдэж байгаа өнөө үед хүнсний аюулгүй байдалд бодит аюул занал учирч буй энэ чиглэлд анхаарлаа хандуулна.



**УРСУЛА ФОН ДЕР ЛЕЙЕН**  
*Европын комиссын ерөнхийлөгч*

Европын холбоо уур амьсгалын санхүүжилтийг төсөвтөө багтаан хэрэгжүүлэх болно. Үүнд их хэмжээний хөрөнгө оруулалт хэрэгтэй. Энэ нь бидний өмнө сорилт болж байгаа ч Европ үйл ажиллагаагаа чиглүүлэн удирдах хүч чадалтай. Европ илүү сайхан дэлхийг бий болгоход тэргүүлэх үүрэгтэй хүчин зүтгэж чадна.



**ЭЛЬВИРА САХИПЗАДОВНА НАБИУЛЛИНА**  
*ОХУ-ын Төв банкны ерөнхийлөгч*

Хоёрдогч нөлөөллөөс зайлсхийхийн тулд инфляцын хүчин зүйлүүдийн хариуд мөнгөний бодлогоо чангатгасан. Зарлага хэрхэн аажмаар зөв зам руу эргэж байгааг бид харж байна. Төсвийн бодлого илүү их өдөөгдөж, хэвийн байдалд орно. Мөнгөний бодлого эдийн засгийн өсөлтөд нэмэлт эерэг нөлөө үзүүлэх болно.



**КРИСТИН ЛАГАРД**  
*Европын Төв банкны ерөнхийлөгч*

Евро бүсийн эдийн засгийг хөтлөх, инфляцыг хянах зэрэг банкны уламжлалт бодлогоос хальсан арга хэмжээ авна. Аливаа тооцоолол гаргах бүрдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх эрсдлийг заавал тусгаж байх болно.



**КРИСТАЛИНА ГЕОРГИЕВА**  
*ОУВС-гийн гүйцэтгэх захирал*

Төсвийн илүү орон зайг бий болгох нэг арга бол дотоодын орлогыг дайчлах явдал юм. Авлигыг бууруулах, татвар хураахад дижитал хэрэгсэл ашиглах нь нөөцийг нээж, хүмүүст шинэ хөрөнгө оруулалт хийх боломж олгодог. Энэ нь 2030 оны тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэхэд улс орнуудад тусалж чадна.



# Сүмо тайлбарлагч М.Цолмонбаяр Mitsubishi-г мэхэлсэн үү

Хамажима Хироаки: Манай компани Цолмонбаярын байгуулах гэж буй дэвжээнд огт хөрөнгө оруулалт хийгээгүй

Б.Мөнхзул, ЗГМ сонин

Японы мэргэжлийн сүмо бөхөд Китакасүгава нэрээр барилдаж байгаад зодог тайлсан сүмо тайлбарлагч М.Цолмонбаяртай холбоотой таагүй мэдээлэл цацагдсан. Энэ бол түүнийг Монголдоо сүмогийн дэвжээ байгуулах нэрээр бусдаас их хэмжээний мөнгө зээлсэн ч түүнийгээ буцааж төлөөгүй, мөн “хандив өргө” гэж нөлөө бүхий хүмүүсийг дарамталсан тухай юм. Тэр ч бүү хэл Монголоос Япон руу хүүхнүүд аваачиж биеийг үнэлүүлдэг тухай дурджээ. Хэрвээ монголчуудаас хохирсон хүн байвал холбогдож болох хаягийг оруулсан байв.

Уг мэдээлэлд дурдсанаар М.Цолмонбаяр нь 2019 оны арваннэгдүгээр сарын 27-нд Улаанбаатарт сүмогийн дэвжээнийхээ нээлтийг хийсэн байх ёстой. Гэвч тухайн өдөр ямар ч дэвжээний нээлт болоогүй юм. Харин уг дэвжээний шав тавих ёслол өнгөрсөн наймдугаар сарын 12-нд “Монгол Коосэн” техник, технологийн дээд сургуулийн кампус дотор болсон байна. “Уг дэвжээг Монголын өсвөр, залуучуудын сүмо бөхийн холбооны ерөнхийлөгч Китакасүга М.Цолмонбаярын



2019 оны наймдугаар сарын 12-нд Сүмогийн дэвжээний шав тавих ёслол болсон бөгөөд үүнд М.Цолмонбаяр, Хироаки тэргүүтэн оролцсон.

ЗГМ

**М.ЦОЛМОНБАЯРЫГ БУСДААС ИХ ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ ЗЭЭЛСЭН Ч ТҮҮНИЙГЭЭ БУЦААЖ ТӨЛӨӨГҮЙ, МӨН ХАНДИВ НЭХЭЖ ДАРАМТАЛСАН ТУХАЙ ДУРДЖЭЭ.**

санаачилгаар байгуулж, Японы Mitsubishi корпорац ивээн тэтгэж байна” хэмээн тухайн үедээ мэдээлэл хүргэж байв. Гэтэл өнөөдөр өнөөх дэвжээ

шав тавиад л зогссон байдалтай байна. Бид дээрх сургуулийн захирал М.Сэргэлэнтэй холбогдоход “Дэвжээ барих асуудал хөрөнгө оруулалт гацсанаас болоод зогссон. Одоогоор өөр тодорхой мэдээлэл өгөх боломжгүй байна” гэв. WIKI.JP сайтад нийтэлсэн мэдээллээр бол М.Цолмонбаяр нь дэвжээ байгуулахын тулд Mitsubishi-гээс дэмжлэг авсан ч өнөөдөр дэвжээ нь шав тавьснаас өөр зүйлгүй байгаа учраас ацан шалаанд оржээ. Харин энэ талаар Mitsubishi корпорацийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал Хамажима

Хироаки “Цолмонбаярын тухай гарсан мэдээлэл дээр ямар нэгэн тайлбар хэлэхгүй. Бидэнд мэдээлэл алга. Японы Гадаад явдлын яамнаас манай компанид анхааруулга өгсөн албан бичиг ирээгүй байна. Ер нь бол WIKI.JP сайт дээр гарсан мэдээлэл ташаа гэдгийг хэлье. Манай компанийн зүгээс Цолмонбаяртай ямар нэгэн байдлаар холбоогүй гэдгийг албан ёсоор мэдэгдэж байна. Бид Монголд байгуулагдах дэвжээнд хөрөнгө оруулалт хийх талаар судалж үзсэнээс цаашгүй. Үнэнд нийцэхгүй ийм мэдээлэл цацагдсанд харамсаж байна” гэв. ■

## “Өвлийн идэш” махны үзэсгэлэн худалдаа болно

Улаанбаатарт амьдарч буй хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилготой “Өвлийн идэш” нэгдсэн арга хэмжээ маргааш эхлэх гэж байна. 10 хоногийн турш зохион байгуулах

махны өргөтгөсөн худалдаа “Скай”, “Саруул”, “Сансар” худалдааны төвийн гадна талбайд болно. Тус үзэсгэлэнд 11 аймгийн малчид хямд үнээр махаа нийлүүлэх юм. ■

## Сүхбаатарын талбайд мөсөн хотхон байгуулна

Д.Сүхбаатарын талбайд “Бидний хот” сэдэвт мөсөн хотхон байгуулах уралдаан зарлажээ. Уралдааныг нийслэлийн 380 жилийн ойг тохиолдуулан зарлаж байгаа бөгөөд энэ сарын

11-нд шилдгүүдийг тодруулна. Улмаар шалгарсан төслийн баг, уран бүтээлчид тухайн өдөртөө НЗДТГ-тай гэрээгээ байгуулж, төв талбайд мөсөн хотхоноо сүндэрлүүлэх нь. ■

## ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос XII.5.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /улсын хэмжээнд/ Багц-37 ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос:

Багц-37: XII.5.1.1.33 Усан спортын барилгын засвар /Говьсүмбэр, Сүмбэр сум/-ийн ажлуудыг тус тус гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 10.30 цагаас өмнө

цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11.00 цагт нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг,  
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР,  
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо,  
Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр,  
Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 263014, 267435  
Цахим хаяг: www.tender.gov.mn

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Залилан, луйвраас ₮13 тэрбумын хохирол учруулжээ

Санхүүгийн залилан, луйврын шинжтэй гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагууд хохирох нь сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна. 2016 онд залилангаас болж хохирсон хохирлын хэмжээ хоёр тэрбум төгрөг байсан бол 2019 оны эхний 11 сарын байдлаар 13 тэрбум болж, 6.5 дахин нэмэгдсэн байна. Иймд Монголбанк, Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо хамтран иргэд, олон нийтэд чиглэсэн санхүүгийн залилан, луйвраас сэрэмжлүүлэх зорилготой “Ятгах тусам нягтал” аяныг эхлүүлжээ.

Уг аяны хүрээнд олон нийтэд хандан санхүүгийн залилан, луйвраас урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ, мэдээллийг хүргэх аж. Түүнчлэн иргэдийн эрх зүйн болон санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх болоод санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зөв сонгох талаарх мэдлэг, ойлголт өгнө. Аяныг зохион байгуулагчдын зүгээс иргэдийг болзошгүй залилан, луйвраас өөрийгөө болон бусдыг хамгаалж, урьдчилан сэргийлэхийг уриаллаа. ■

## ОФИССЫН ТАЛБАЙ ТҮРЭЭСЛҮҮЛНЭ

Энхтайвны гүүрний баруун урд талд, Дунд голын хойд эрэг дээр баригдсан 2020 оны I улиралд ашиглалтанд орох гаднаа 70 автомашины зогсоолтой 13 давхар барилгын 8-12 давхрыг офиссын зориулалтаар түрээслүүлнэ. 1 давхрын талбай – 500 мкв

Утас: 91188819,  
и-мэйл:  
tseeb.llc@gmail.com

## OFFICE SPACE FOR RENT

We are offering 500 sq. office spaces on the 8-12th floor in our new office building. It will be commissioned in the first quarter of 2020. Located just southwest side of the Peace Bridge (on the banks of the “Dund gol” river), you can feel natural light and view during all day long through big windows. Outside parking is well enough for workers and guests.

For further information contact at 91188819, tseeb.llc@gmail.com



# “Хөгжлийн зам”-д хурд хайрлаач

Налайхын замыг тууш замын ангилалд багтааж хөдөлгөөний хурдыг нэмэх боломжтой

Б.Гарьд, ЗГМ сонин

**Ө**нгөрсөн сард нээлтээ хийсэн Улаанбаатар-Налайхын чиглэлийн 20.9 км замын тууш хайчлах ёслолын үеэр Ерөнхий сайд У.Хүрэлсүх “Энэ бол хөгжлийн зам” хэмээн тодорхойлж байсан. Гэвч тэр зам хөгжилд хөтлөх биш хөлд “тушаа” болж байна.

Налайх дүүрэг Улаанбаатарын төв цэгээс 42 км зайтай. Тэндээс нийслэлийг зорьж ажил, албандаа ирдэг иргэн олон. Дүүргийн удирдлагууд ч хүн амынх нь гуравны нэг нь нийслэлд ажил, алба хашдаг талаар өгүүлж байв. Гуравны нэг нь гэхээр 37 мянган иргэний 10 мянга нь өглөө бүр нийслэлийг зорьж их хотын амьдралд хөл нийлүүлдэг гэсэн үг. Хар ухаанаар тооцвол айл бүр машинтай болсон өнөө үед 10 мянга гаруй өрхийн гурван мянга орчим нь Улаанбаатар-Налайхын замаар автомашинтай зорчиж байгаа гэх дүгнэлтэд хүргэнэ. Харин тэдгээр иргэн сайхан замаар, саарсан хурдаар ажил, албандаа гэлдэрч байгаа юм. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн дагуу эл замд 60 км/цагаас илүү хурдлах боломжгүй. Хэтрүүлбэл замын хажууд хурд хэмжигч барьсан цагдаагийн ажилтан 50 мянган төгрөгөөр торгож, жолооны ард суух эрхийг зургаан сар хасах гээд хүлээж байдаг учраас гэлдрэхээс аргагүй. Гэвч хэдий хүртэл “хөгжлийн зам”-аараа хөгийн хурдаар сажилсаар байх вэ. Хорин минутад ирж, очих боломжтой замаар бүтэн цаг гэлдэрнэ гэдэг зөв оновчтой хэмнэл яав ч биш.

Үүнийг бодлогоор зохицуулж, хөгжилд, цаг үед нийцүүлэх боломж бүрэн бий. Бүр 100 км/цаг хүртэл хурдтай зорчих эрхийг ч жолооч нарт нээж өгөх боломжтой. Монголын замд зөвшөөрөгдсөн дээд хурдыг 80 км/цаг гэж ихэнх жолооч ойлгодог. Замын цагдаа ч 80-аас дээш хурдалбал зогсоож, торгох, эрхийг хасах, журамлах шийтгэлийн аль нэгийг оноосоор байгаа. Гэвч тийм биш. Цагт 100 км хүртэл хурдлахыг хуулиар зөвшөөрсөн байна. Засгийн газар 2018 онд 239 тоот тогтоолын хавсралтаар Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийг шинэчлэн батлахдаа дээд хурдыг 100 км/цаг болгон шинэчилсэн. Тухайлбал, тус хуулийн 12.4-т “Тээврийн хэрэгслийн хурдыг суурин газарт цагт 60 км, суурин газрын гадна цагт 80 км, тууш замд цагт 100



Гэрэл зургийг С.Батсайхан

км-ээс хэтрүүлэхийг хориглоно” гэжээ. Замын хөдөлгөөний дүрэм бол хууль. Тиймээс хуулиар зөвшөөрсөн дээд хурдыг тууш замд ашиглах боломжтой. **Тууш зам гэдэг эсрэг хөдөлгөөний зорчих хэсгүүд нь хоорондоо тусгаарлах зурвас, замын хашилтаар зааглагдсан, явган болон унадаг дугуйн зам, мөн төмөр замтай нэг түвшинд огтлолцоогүй замыг хэлдэг. Энэ стандартаар Налайхын зам тууш замын шаардлагыг яах аргагүй хангаад байгаа юм. Харин хурдыг нэмэх гогцоо нь “суурин газар” гэсэн**

**УГ НЬ НАЛАЙХЫН СУУРИН ГАЗРЫН ТЭМДЭГЛЭГЭЭГ ДҮҮРГЭЭС НЭГ КМ ЗАЙД, УЛААНБААТАРЫН СУУРИН ЗАМЫН ТЭМДЭГЛЭГЭЭГ БАЯНЗҮРХИЙН ТОВЧООНЫ ЦААХНА БАЙРЛУУЛАХАД Л 20 КМ ТУУШ ЗАМ БЭЛЭН ЮМ.**

**тэмдэглэгээнд баригдаж, улаан хүрээтэй жарын тоотой тэмдэгт тушигдчихаад байна.** Уг нь Налайхын суурин газрын тэмдэглэгээг дүүргээс нэг км зайд, Улаанбаатарын суурин замын тэмдэглэгээг Баянзүрхийн товчооны цаахна байрлуулахад л 20 км тууш зам бэлэн юм. Ийм зэргийн зохицуулалт хийх эрх нь Ерөнхий сайдын мэдэлд бий. Уг нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийг тэргүүлдгийн хувьд үзэгний үзүүрээр л шийдчих зүйл. Замын цагдаагийнхан ч ийм шийдлийг санаачлаад шийдүүлж болох шүү

дээ. Тэр байтугай хурдны замын хуульгүй байж, тахиралдаж, мушгирсан шинэ нисэхийн замыг хурдны гэж нэрлээд цагт 80 км хурдлахыг зөвшөөрч болсон юм чинь Налайхын замыг тууш зам болгох тийм хэцүү зүйл биш шиг байлтай. Заавал 100 км/цаг болгох албагүй. Аюулгүй байдал, хөдөлгөөний соёлоо тооцоод, ядаж цагт 80 км-ын хурдаар ажил, албандаа түргэн хүрэх боломжийг олгох нь чухал байгаа юм.

**УЛААНБААТАР-НАЛАЙХЫН ЗАМААР 100 КМ/ЦАГИЙН ХУРДТАЙ ЯВАХ БОЛОМЖ Ч БИЙ.**

Улаанбаатар-Налайхын замд хурд нэмэх нь дан ганц налайхчуудын ашиг сонирхолтой биш шүү. Зүүн болон дорно зүгийн аймгуудаас ирж буй ачаа тээвэр, хот хооронд зорчигчдод ч ашигтай. Мөн өмнөд хөршөөс ачаа тээвэрлэж буй монгол жолооч төдийгүй олон улсын транзит тээвэрт ч нэн ашигтай. Орон нутгийн замд 80 км/цагийн хурдтай явсан тээврийн хэрэгсэл “суурин” тэмдэгтэд баригдаж 20 км газар хурдаа дөрөвний нэгээр хасна гэдэг тэр хэрээр цагийн алдагдал, шатахууны илүү зардал гаргаж байна. Тэгээд ч Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 12.2-т жолооч саадгүй зорчих эрхтэй гэж заасныг тунгаах буй за.

Хувийн хохирлыг хойш тавья гэхэд улсын эдийн засагт сөрөг нөлөөлөл их бий. Нийслэлийн удирдлага Налайхын цаахна аж үйлдвэрийн цогцолбор барихаа зарлаж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн, УИХ, Засгийн газрын түвшинд ч тус цогцолборыг иж бүрэн тохижуулахаар ярьж эхлээд буй энэ үед хүрэх замыг “чөдрөөс” чөлөөлөх нь эдийн засагт хурд нэмэх нь гарцаагүй. Ингэхийн тулд Улаанбаатар-Налайх чиглэлийн замд хурд зайлшгүй хэрэгтэй нь тодорхой байна. Харин замаа засаж хөөрцөгөлөө ч өнгөрсөн зууны хурдаар гэлдрээд байвал шинэ зууны хөгжлөөс хоцорсоор байх нь дамжиггүй. Тиймээс иргэдэд ашигтай, эдийн засагт хэрэгтэй зохицуулалтыг даруй шийдэх шаардлага тулгарч байна.

Он гараад Замын хөдөлгөөний Үндэсний зөвлөл хуралдана. Тэр хурлаас “Хөгжлийн замдаа” хурд хайрлаач гэж хүсэх байна. ■



# ЭДИЙН ЗАСАГ

- ⊖ Тэрбум ам.долларын алдагдалтай худалдааг шинжихүй → 9
- ⊖ “Рио Тинто” \$1.5 тэрбумын хөрөнгө оруулна → 10

- ⊖ Төрийн өмчит компаниудад зоригтой реформ хийгээсэй → 10
- ⊖ Хятад хүүхдүүд ухаанаараа дэлхийд тэргүүллээ → 11

## ЗГМ: ТОВЧХОН

### ■ АРИЛЖАА

Монголын хөрөнгийн бирж лхагва гарагийн үнэт цаасны арилжаагаар 31 компанийн 1,044,142 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр зургаан компанийн хувьцааны ханш өсөж, 21 компанийнх буурав.

### ■ ИНДЕКС

# 1.81

Хувь. ТОП 20 индекс 1.81 хувиар өсөж, зах зээлийн үнэлгээ 2.49 их наяд төгрөгт хүрлээ.

### ■ БАНК, САНХҮҮ

# 14

Хувь. 2009 оноос хойш 10 жилийн хугацаанд төв банкуудын алтны нөөц 14 хувиар өсөөд байна. ОХУ-ын алтны нөөц аравдугаар сард өмнөх сарынхаас өсөж, 72.4 сая унц болжээ. Харин БНХАУ 10 сар дараалан алтны нөөцөө нэмсэн бол өнгөрсөн аравдугаар сард нөөцөө өмнөх түвшинд нь хадгалсан байна. Тус улсын нөөц 62.6 сая унцаар хэмжигдэж байна.

### ■ УУЛ УУРХАЙ

# 56.6

Мянга. Уул уурхайн салбарт 56.6 мянга гаруй хүн ажиллаж байгаагийн 57 хувь нь үндсэн, 43 хувь нь гэрээт болон туслан гүйцэтгэгч компанийн ажилтан байна гэж Ашигт малтмал, газрын тосны газар мэдээллээ. Ашигт малтмал, газрын тосны газарт 2018 онд ирүүлсэн 263 тайлангийн мэдээлэлд тулгуурлан энэхүү тооцоог гаргажээ.

### ■ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

# 58.7

Хувь. Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр улсын хэмжээнд энэ оны гуравдугаар улирлын байдлаар 126,582 хүн ажилгүй байна. Үүний 58.7 хувь нь эрэгтэйчүүд аж.

# Ипотекийн зах зээл зургаан жилийн дотор 5.3 дахин өсжээ

Найман хувийн хүүтэй зээлийн хүртээмж улам хумигдах жил айсуй

✍ Б.Баяртогтох, ЗГМ сонин

Найман хувийн хүүтэй ипотека хэрэгжээд даруй зургаан жил болжээ. Энэ хугацаанд нийт 95 мянган иргэн энэхүү зээлд хамрагдаж, уг хөтөлбөр өдгөө дөрөв дэх Засгийн газрын нүүрийг үзэж байна. Төв банкны хоёр ч ерөнхийлөгчийн гараар орлоо. Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр 2013 оноос хэрэгжиж эхэлсэн. Тэгвэл энэ оны гуравдугаар улирлын байдлаар шинээр 6899 иргэн ипотека авчээ. Өнгөрсөн онд нийт 9.3 мянган иргэн энэхүү хөтөлбөрт хамрагдаж байсан бол хөтөлбөр анх хэрэгжиж эхэлсэн үетэй харьцуулахад зээл олголт өнөөдөр 2-3 дахин хумигдсан. Өөрөөр хэлбэл, санхүүжилт тэр хэрээр багассан гэсэн үг. Хэдий тийм боловч ипотекийн зах зээл зургаан жилийн дотор 5.3 дахин өсжээ.

Тэрчлэн хөтөлбөр хэрэгжихээс өмнө иргэдийн авдаг ипотекийн дундаж хэмжээ 39.1 сая төгрөг байсан бол 72.8 сая болж өсөв. Үүнээс гадна ипотекийн зээлийн хугацаа 17.2 жил болж уртассан байна. Өмнө нь буюу 2012 онд 13.2 жил байв. Өндөр хүүтэй орон сууцны зээлийн тогтолцоотой үед сарын 3-4 сая төгрөгийн орлоготой иргэдэд олддог байсан зээл уг хөтөлбөрийн үр дүнд 1-1.5 сая төгрөгийн орлоготой өрхөд ч хүртээмжтэй болсон. Тэрчлэн өрхийн хэрэглээний бүтцийг өөрчилж, хуримтлал болон үл хөдлөх хөрөнгийн өмчтэй болоход ипотека дэмжлэг болсон юм. Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжилд ч ипотека томоохон байр суурь эзэлдэг боллоо. Ипотекийн хоёрдогч зах зээлд ипотекийн зээлээр баталгаажсан бондыг нэвтрүүлж, энэ нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд хүч сэлбэсэн билээ.

Ипотекийн зээлийн үлдэгдэл өнөөдөр 4.53 их наяд төгрөг болж, харьцангуй нэмэгдсэн байна. Энэ нь 2020 оны улсын төсвийн




Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

зарлагын гуравны нэгтэй тэнцэх дүн юм. Энэ оны есдүгээр сарын байдлаар хөтөлбөрийн нийт зээлийн 92 хувийг Монголын Ипотекийн Корпораци худалдан авсан зээл нийт ипотекийн үлдэгдлийн 67 хувийг эзэлж байна. Энэ нь 3.9 их наяд төгрөг аж. Худалдаа, үйлдвэрлэл, барилга, үйлчилгээний салбарт ипотека эерэг нөлөө үзүүлсэн төдийгүй нийгмийн даатгалын салбарыг ч дэмжсэн гэж болно. Иргэд нийгмийн даатгал төлж, улсын Нийгмийн даатгалын сангийн орлого сүүлийн зургаан жилд тогтмол нэмэгдсэн байна. Ялангуяа, барилгын салбарт буюу дотоодын барилгын материалын үйлдвэрлэлд энэхүү хөтөлбөр шууд нөлөө авчирсан юм.

Гэвч Засгийн газар жил ирэх тусам ипотекийн санхүүжилтийг хумих болов. Тухайлбал, ирэх онд 60 орчим тэрбум төгрөг орон сууцны зээлийн санхүүжилтэд хуваарилсан нь олон өрхийн орон сууцтай болох найдварыг үгүй хийх нь. Төсөвт тусгасан санхүүжилтийг энэ он болон өнгөрсөн онтой харьцуулахад 2-3 дахин буурсан үзүүлэлт. Өнгөрсөн онд 9.3 мянган иргэн орон сууцтай болсон бол санхүүжилт ийн буурснаар энэхүү хэмжээ 2020 онд хоёр

## ЗЭЭЛИЙН ЕРӨНХИЙ ШИНЖ ЧАНАР

Худалдан авсан орон сууцны талбайн хэмжээ



Зээлдэгчийн ажил эрхлэлтийн байдал



- 54.01% Аж ахуйн нэгж
- 33.00% Төрийн байгууллага
- 12.99% Бусад

Эх сурвалж: МИК

дахин буурахаар байгаа юм. Уг нь нийслэлийн агаар болон хөрсний бохирдлыг бууруулах хамгийн бодитой шийдэл нь орон сууцжуулалт билээ. Харамсалтай нь, Засгийн газар уг хөтөлбөрт гар татсан хэвээр. Ирэх оноос ипотекийн хөтөлбөрөөс төв банк гарч, уг хөтөлбөрийг цаашид Засгийн газар хэрэгжүүлэх учиртай. Сонгуулийн жил ипотекийн санхүүжилт нэмэгдэх бус эсрэгээрээ улам хорогдлоо.

Төв банк найман хувийн зээлд зориулан энэ оны 11 сарын байдлаар 155.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2000 гаруй иргэнд олгожээ. Харин Засгийн газрын эх үүсвэр үүнээс хоёр дахин бага байгаа юм. Эргэн сануулахад, 2013

онд орон сууцны борлуулалт хоёр дахин нэмэгдсэн бөгөөд үүний 63 хувийг ипотекийн зээлээр борлуулж байв. Тодруулбал, жилд 38.2 мянган орон сууц зээнтэй болсон бол өнөөдөр зээлийн санхүүжилтийг хумих хэрээр зээлийн олдоц эрс багассан. Иргэдийн авч буй зээлийн дундаж хэмжээ 55.3 сая төгрөг байгаа бол зээлдэгчдийг авч үзвэл, 70 гаруй хувь нь нийслэлд орон сууц худалдан авчээ. Орон нутагт гэвэл, Дархан-Уул, Орхон аймгийн иргэд хамгийн их орон сууц зээлээр авсан байна. Зээл авсан иргэдийн 54 хувь нь хувийн хэвшилд ажиллаж байгааг Монголын Ипотекийн Корпорациас мэдээллээ. ■





✎ Б.Мөнх-Эрдэнэ, ЗГМ сонин

**Е**рөнхий сайд У.Хүрэлсүхийн ОХУ-д хийж буй албан ёсны айлчлал үргэлжилж байна. Хоёр улсын эдийн засгийн харилцааг шат ахиулах түүний айлчлалтай холбогдуулан Орос, Монголын худалдаа тоон дүнгээр ямар түвшинд байгааг сонирхлоо. Худалдааны эргэлтийг авч үзвэл, хэдхэн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүн эргэлдэх бөгөөд үүнд нефтийн бүтээгдэхүүн хамгийн их жин дарна байна. Хэдий тийм боловч хоёр улсын худалдааны алдагдал жилд нэг

тэрбум ам.доллараас буурахгүй өдий хүрэн. Худалдааны тэргүүлэх бараа, бүтээгдэхүүнийг жагсаавал, жонш, нефтийн бүтээгдэхүүн, тусгай зориулалтын машин механизм, түүний тоног төхөөрөмж, азотын бордоо, арматур, цувимал төмөр давамгайлах аж.

**ОХУ-д гаргаж буй манай улсын экспорт ердөө 100 хүрэхгүй сая ам.доллараар хэмжигддэг аж. Импорт, экспортын зөрүү худалдааны алдагдлыг улам тэлсээр.** Импортын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг нефтийн бүтээгдэхүүн ороод жилд тэрбум ам.доллар хол давсан бараа, бүтээгдэхүүн

📷 Гэрэл зургийг С.Батсайхан

**МАНай ХОЁр УЛСЫн ХУДАЛДАА 2016 ОНООС СЭРГЭЖ, 2017 ОНООС ЭХЛЭН ӨСӨХ ХАНДЛАГАТАЙ БАЙСАН БОЛ ЭНЭ ОНЫ ЭХНИЙ ЕСӨН САРЫН БАЙДЛААР 13 ХУВИАР НЭМЭГДЖЭЭ.**

манай улс хойд хөршөөсөө авч байна. Манай улсын геологи хайгуул, уул уурхай, хүнс, барилга, хөнгөн үйлдвэрлэл, эрчим хүч, тээвэр болон аялал жуулчлалын салбарт ОХУ-ын хөрөнгө оруулалттай 700 гаруй аж

# Тэрбум ам.долларын алдагдалтай худалдааг шинжихүй

ОХУ, Монголын худалдаа өсөх хандлагатай байна

ахуйн нэгж бүртгэлтэй байдгаас 80 хүрэхгүй нь үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл, 10 гаруйхан хувь нь ажилладаг гэсэн үг. **Тэгвэл валютний ханшийг сонирхвол төв банкны зарласан албан ханшаар рубль лхагва гарагийн байдлаар 42.37 төгрөгтэй тэнцэж байна. Энэ оны аравдугаар сард төгрөгийн рубльтэй харьцах ханш өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар суларчээ.**

Рублийн ханш чангарч, төгрөгийн ханш улам суларсаар байвал ОХУ-тай хийх худалдааны алдагдал тэр хэрээр нэмэгдэнэ гэсэн үг. Манай улс Хятадын Ардын банкттай үндэсний мөнгөн

тэмдэгт солилцох своп хэлцэл байгуулсан. Тэгвэл ОХУ-тай мөн энэ төрлийн хэлцэл байгуулахаар эртнээс ярьж буй. Төв банкны удирдлагууд өмнө нь албан ёсоор хандаж байсан ч тодорхой шийдэлд хүрээгүй өдгөө хүрлээ. Байгалийн хийн хоолойг Монголын нутгаар дамжуулах, Владивостокт Монгол Улс худалдааны төлөөлөгчийн газраа нээх боломжийг бүрдүүлэхээр зорьсон Ерөнхий сайдын айлчлалаар яригдаж байна. Манай хоёр улсын худалдаа 2016 оноос сэргэж, 2017 оноос өсөх хандлагатай байсан бол. Энэ оны эхний есөн сарын байдлаар 13 хувиар нэмэгджээ. ■

## МӨНГӨНИЙ БОДЛОГО

# Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах асуудлыг хуульчилснаар үүсэх давуу талууд

Иргэд банк санхүүгийн харилцаанд ороходоо санхүүгийн боловсрол, мэдлэг, мэдээлэл дутмагаас болж хохирол явдал их бий. Энэ байдал нь зөвхөн иргэдийг хохироогоод зогсохгүй, цаашилбал банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал ч муу нөлөөтэй юм. Энэ нөхцөл байдлаас сэргийлэхийн тулд санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах нь чухал гэдгийг дэлхий нийт 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараа ойлгосон байдаг.

Бодит байдалд иргэн банкинд дээр очоод, зээлийн эдийн засагчийн өмнө суухдаа хүч тэнцвэргүй харилцаанд ордог байна. Нэг талаас зах зээлийн болон эдийн засгийн бүхий л мэдээллийг харж, мэдэж буй банкны ажилтан. Нөгөө талаас зөвхөн зээлээ л авч байвал үндсэндээ юу ч хийсэн яах вэ гэх бодолтой иргэн. Энэ тохиолдолд иргэдийг бодит мэдээллээр хангаж, зээлийн шаардлага, эрсдэл, нөхцөл нь ямар байх, эргээд иргэн хүний

амьдралд энэхүү зээл ямар хүндрэл учруулж болох талаар дэлгэрэнгүй тайлбарлах үүрэгтэй бөгөөд уг асуудлыг дэлхийн ихэнх оронд хуульчилсан байдаг.

Манай улсын хувьд Улаанбаатар хот болон 20 аймгийн 3257 иргэний дунд санамсаргүй түүврийн аргаар хийсэн судалгаагаар иргэд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл авч чаддаггүй болох нь харагдаж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан иргэдийн 50 хувь нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар бүрэн мэдээллийг олж авч чаддаггүй гэсэн бол 3 хүн тутмын 1 нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой ямар нэг хүндрэлтэй тулгарч байсан гэж хариулжээ. Нийт хүндрэлийн 50 хувь нь бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл дутмаг, зар сурталчилгаа болон ажилтны танилцуулсан мэдээлэл бодит байдлаас зөрүүтэй байдлаас болж үүссэн гэсэн бол үлдсэн хэсэг нь дансны хуулга авах, банкны

шийдвэрээр шимтгэл хураамж авах, мэдээллийн нууцлалтай холбоотой хүндрэлүүд байдаг талаар дурдсан байна.

Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч хоорондын энэхүү мэдээллийн зөрүүтэй байдал хэрэглэгчийг хохироох үндсэн шалтгаан болж буй учир Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хуульчлах шаардлагатай байгаа аж. Төв банкны тухай хуулинд 2018 онд орсон өөрчлөлтөөр төв банкны үүрэгт санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалан функц нэмэгдсэн. Үүний дагуу санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг хуульчлахад шаардлагатай болж, хуулийн төслийн судалгаа, боловсруулал, олон нийтийн хэлэлцүүлэг зэргийг үе шаттайгаар хийснээр УИХ-д өргөн бариуллаа.

Хуулийн төсөлд санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой тодорхой зохицуулалтуудаас гадна мөнгө хүүлэлт гэж юу болох, ямар

тохиолдолд мөнгө хүүлэлт гэж үзэх, Монгол Улсын хэмжээнд үйлчлэх хүүгийн дээд хязгаарыг тогтоох зэрэг асуудал багтаж буйгаараа онцлог юм. Хуулийн төсөл батлагдсанаар дараах үр дүн хүлээгдэж байна. **Үүнд:**

- Санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн мэдлэг, боловсрол дээшилснээр өөрт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээг зөв сонгон хэрэглэх ба ирээдүйд үүсэх санхүүгийн дарамтаас өөрийгөө хамгаалах чадавхитай болно,

- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тавих шаардлагыг зөв тогтоосноор шударга өрсөлдөөнт зах зээлийг бүрдүүлэх, санхүүгийн байгууллагын урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ,

- Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалаад зогсохгүй үүргийг нь зөв тогтоосноор санхүүгийн хэрэглэгчийн санхүүгийн сахилга бат болон

хариуцлагыг ухамсарлуулах ба ингэснээр чанаргүй зээлийн хэмжээг багасгаж, зах зээлийн эргэх холбоог сайжруулна,

- Санхүүгийн маргааныг шийдвэрлэх мэргэшсэн байгууллагыг зөв системтэйгээр байгуулснаар гомдол, маргааныг шийдвэрлэх механизм нь илүү хурдан шуурхай, зардал багатай болохоос гадна шүүхийн журмаар шийдвэрлэгддэг маргааны тоо багасаж, шүүхийн байгууллагын ачааллыг бууруулна.

- Хэрэглэгчийн санхүүгийн боловсрол, мэдлэг дээшилэхийн хэрээр хариуцлагатай зээлийн тогтолцоо бүрдэх ба мөн өндөр хүүтэй мөнгө хүүлэлтийн эсрэг чиглэсэн нийгмийн дархлааг дэмжинэ.

- Төрийн зохицуулагч байгууллагууд нь нэг салбарын хэрэглэгчийн эрхийг тус тусын хууль, журмаар хамгаалж, түүнд тавих хяналт зохицуулалтыг хамтдаа хийдгийг болиулах ба үүрэг, функцийг давхардал, хийдлийг арилгана. ■





Гэрэл зургийг С.Батсайхан

Б.Дашням, шинжээч

**А**т Cham Mongolia-гийн гүйцэтгэх захирал О.Адъяатай ярилцлаа. Алдагдалтай ажилладаг төрийн өмчит компаниудад реформ хийж, хувьчлах зайлшгүй шаардлагатайг тэрбээр ярилцлагадаа онцлов.

**-Танай байгууллагад Монголын томоохон бизнесийн байгууллагын дийлэнх нь бүртгэлтэй байдаг. Бизнесийн салбарынхны хувьд ирэх онд ямар хүлээлттэй байна вэ?**

-2020 он бол сонгуулийн жил. Тиймээс сонгуулиас өмнөх болон сонгуулийн дараах гэсэн хоёр үе шат байх болов уу. Манай бизнесийнхэн ерөнхийдөө хоёр асуудлыг л яриад байгаа. Нэгдүгээрт, саарал жагсаалтаас гарахад хувийн хэвшлийн оролцоо ямар байх вэ, танхимын гишүүд Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд хэрхэн тусалж болох вэ гэдгийг

эрэлхийлж байна. Монгол Улс саарал жагсаалтад орох гээд байна, нөхцөл байдал хүндрэх нь гэж бид 2017 оноос хойш сануулж байсан. Өөрөөр хэлбэл, манай гишүүн байгууллага энэ тал дээр туршлагатай.

Дараагийн зүйл нь шинэчлэлтэй холбоотой. Сонгуулийн дараа шинэ засаг бүрдэнэ. Шинээр байгуулагдсан Засгийн газар төрийн өмчит компаниудад зоригтой реформ хийгээсэй гэж хүсэж байна. **Өнөөдөр Монголд 100 гаруй төрийн өмчит компани бий. Тэдний ихэнх нь алдагдалтай ажилладаг. Төрийн өмчит компаниудад реформ хийхэд хувийн хэвшлийнхэн дуу хоолойгоо нэмэрлэж, хамтарч ажиллая гэж бодож байгаа. Төрийн өмчит компанийг амжилттай хувьчилж, хөрөнгийн биржид хувьцаа гаргаж, хувийн хэвшлийн оролцоог хангаж болно гэдгийг “Монгол шуудан” компанийн жишээнээс харлаа шүү дээ.**

**-Таны ярьснаас ургуулан асуухад хувийн хэвшлийнхэн**

**төрийн өмчит компаниудад өрсөлдөхөд нөхцөл байдал ямар байна вэ?**

-ТОП 100 аж ахуйн нэгжийн жагсаалтыг харахад төрийн өмчит компаниуд дандаа дээгүүр бичигддэг. Тоглоомын дүрмээ тодорхойлдог төр маань өөрөө бизнес рүү орохоор хувийн хэвшлийнхэнд хүндрэлтэй. Жишээ нь, “Эрдэнэс Монгол” гэхэд доороо маш олон охин компаниуд болчихлоо. Тэр болгон нь хувийн хэвшилтэй өрсөлдөөд байгаа нь шударга бус.

**-2020 оноос татварын багц хуулийн шинэчлэл хэрэгжиж эхэлнэ. Голлох өөрчлөлтүүд бизнесийнхэнд ээлтэй байж чадах болов уу?**

-Манай танхим сүүлийн хоёр жил Сангийн яамтай их ойр ажилласан. Зарим зүйл дээр ойлголцсон, мөн санал зөрөх тохиолдол ч байна. Зарчмын хувьд бид татварын багц хуулийг дэмжиж байгаа. Ер нь татвартай холбоотой ихэнх хуулийг 2006-2008 онд батал-

# Төрийн өмчит компаниудад зоригтой реформ хийгээсэй

Тоглоомын дүрмээ тодорхойлдог төр маань өөрөө бизнесүүд рүү ороод байхаар хувийн хэвшлийнхэнд хүндрэлтэй байна

сан юм билээ. Үүнээс хойш том, реформын шинжтэй өөрчлөлт ороогүй. Манай улс Европын холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын саарал жагсаалтад нэг хэсэг орсон. Энэ нь татвараас зайлсхийх асуудлыг огт зохицуулаагүйтэй холбоотой байсан. Харин энэ асуудлыг багц хуулиараа зохицуулж өглөө. Өмнө нь компани хооронд гадаадын гүйлгээ хийх

зохицуулалт сул байсан. Харин одоо энэ зохицуулалтыг оруулсан гэдэг утгаараа дэвшил боллоо.

Гэхдээ энэ хуулийг дагасан 40 орчим журам гарах ёстой. Сангийн яам яг одоо энэ журмууд дээр ажиллаж байгаа. Хамгийн гол нь дагалдаж гарах журмуудаа

хоёрдмол утгагүй, нэгдсэн байдлаар тайлбарлаж, компаниудад ойлгомжтой байдлаар хийгээсэй гэж хүсэж байна. Манай танхимын зүгээс он гаргаад багц хуулийн мөн чанар, гишүүдэд яаж нөлөөлөх, бизнесийн байгууллагууд юуг анхаарах ёстой вэ гэсэн сэдвээр

дугуй ширээний хэлэлцүүлэг хийхээр төлөвлөж байна.

**-Оюутолгой ордыг ашиглахад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай УИХ-ын тогтоолыг баталсан. Энэ тал дээр ямар бодолтой байна вэ?**

-Rio Tinto-гийн удирдлагууд энэ асуудал дээр хамтарч ажиллахад нээлттэй гэдгээ илэрхийлсэн байна лээ. Бидний хувьд “Оюутолгой”-н гэрээг тууштай дэмжиж ирсэн. Харамсалтай

**Оюутолгойн гэрээ цаашид үргэлжлээд явах ёстой. Энэ гэрээний цаана өчнөөн хүний ажлын байр, их хэмжээний татвар, ханган нийлүүлэлтийн сүлжээнээс асар их өгөөж орж ирж байгааг ойлгоосой гэж хүсэж байна.**

нь, 2019 оны турш “Оюутолгой”-н асуудлыг ярьж, байж болох бүхий л сөрөг талаас нь харуулахыг хичээлээ. Гэхдээ эцэст нь тодорхой хэмжээний шийдэлд хүрсэнд баяртай байгаа.

Мэдээж энэ цаашид үргэлжлэх ёстой. Манай улсад ямар их өгөөж өгч

байгаа билээ. Монголын талын авах ногдол ашиг бол нэг л асуудал. Гэтэл үүний цаана өчнөөн хүний ажлын байр, их хэмжээний татвар, ханган нийлүүлэлтийн сүлжээнээс асар их өгөөж орж ирж байгааг зөв талаас нь ойлгоосой гэж хүсэж байна. ■

## ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

### Чинээлэг залуус өндөр үнэтэй амралтын газруудын эрэлтийг нэмэгдүүлж байна

Э.Ундрэм, шинжээч

Young Affluent Perspective дэлхийн таван тивийн 26 оронд нэгэн сонирхолтой судалгаа хийжээ. Энэхүү судалгаагаар чинээлэг, тансаг эд зүйлд дуртай залуус байршил сайтай, өндөр үнэтэй амралтын байшингуудын эрэлтийг нэмэгдүүлж байна.

Үл хөдлөх хөрөнгө худалдан авч байгаа залуусын ихэнх нь БНХАУ, Сингапур, Бразил, Мексик, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират зэрэг орныхон байгаа аж. Харин үл хөдлөх

хөрөнгийн зах зээл сонирхож байгаа Хойд Америк болон Европын иргэдийн дийлэнх нь нас тогтсон хүмүүс байжээ.

Тэд ойрын гурван жилд Сент Барт, Сан Тропез, Хэмптонс, Аспен, Сан Моритц, Бали, Маврикий зэрэг газарт үл хөдлөх хөрөнгө худалдан авах төлөвтэй байгаа аж. Энэ бүлгийг чинээлэг хөрөнгөтэй 40-өөс доош насны залуу хүмүүс бүрдүүлж байна гэж дээрх судалгаанд дурдсан байна. Түүнчлэн эдгээр худалдан авагчийн бүлгийн бас нэг өвөрмөц тал нь үл хөдлөх

эзэмших туршлага юм.

Ихэнх залуусын хувьд гурав болон түүнээс дээш үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг байна. Харин судалгаанд хамрагдсан хүмүүсийн 14 хувь нь хамгийн багадаа таван үл хөдлөх хөрөнгө эзэмшиж байгаа аж. Хэдий тийм боловч залуучуудад өмнөх үеийнхнийх нь туршлага дутагдаж байна гэж судалгаанд тэмдэглэжээ. Иймд тэд үл хөдлөх хөрөнгө худалдан авахдаа мэргэжлийн зөвлөхүүдээс тусалцаа авах нь түгээмэл байдаг юм. ■

## УУЛ УУРХАЙ

### Rio Tinto \$1.5 тэрбумын хөрөнгө оруулна

Rio Tinto групп АНУ-д байдаг Кеннекотт зэс үйлдвэрлэлийн цогцолборын үйл ажиллагааг тэлэхийн тулд 1.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулахаар боллоо. Тус компани цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүчний технологид ашиглагдаг зэсийн эрэлт цаашид өснө гэж тооцоолжээ. Ялангуяа АНУ-ын зах зээлд зэсийн баяжмалын нийлүүлэлт хомсдолтой байгаа аж. **Өнгөрсөн онд зэсийн баяжмалын нийлүүлэлт 1.1 сая тонн, эрэлт**

**1.8 сая тонн болж байжээ.**

“АНУ-ын зах зээлд зэсийн хомсдол үүссэн. Үүнийг арилгахад Rio Tinto хувь нэмрээ оруулахаар зорьж байна” гэж тус группийн гүйцэтгэх захирал Жан-Себастьян Жак мэдэгдлээ.

Rio Tinto шинэ хөрөнгө оруулалтаа ирэх зургадугаар жилд багтаан хийж, үр дүнд нь шинэ талбайгаас зэсийн хүдэр олборлож, 2026-2032 оны хооронд нэг сая орчим тонн баяжуулсан зэс үйлдвэрлэнэ гэж тооцоолжээ. ■





Өрхийн орлого хамгийн бага 10 хувьд хамаарах хятад сурагчдын унших чадвар хүртэл ЭЗХАХБ-ын гишүүн улсуудын дунджаас илүү гарлаа.



## Хятад хүүхдүүд ухаанаараа дэлхийд тэргүүлээ

Уильям Хоробин

Хятад хүүхдүүд унших, тоо бодох зэрэг шинжлэх ухааны ур чадвараар дэлхийн бусад улсын үе тэнгийнхнээсээ илүү явааг харуулсан судалгаа гарчээ. Энэ нь БНХАУ ирээдүйд хөгжингүй эдийн засаг болж хувирах хангалттай нөөц чадавхтай болохыг нотлов.

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас (ЭЗХАХБ-ОЕСД) гурван жил тутамд 15 настай сурагчдын дунд дэлхий даяар явуулдаг сургалтын чанарын PISA (Programme for International Student Assessment) судалгаагаар Хятадын Бээжин, Шанхай хот, Жянсу, Жөжян мужийн сурагчдын математик болон бусад шинжлэх ухааны ур чадвар тус байгууллагын гишүүн улсуудынхаас илүү байгаа нь тодорчээ. Сонирхолтой нь, хятад сурагчдын ар гэрийн орлого

ЭЗХАХБ-ын гишүүн улсуудын дунджаас хавьгүй доогуур нөхцөлд ч шинжлэх ухааны ур чадвар нь илүү байгаа юм. Өрхийн орлого хамгийн бага 10 хувьд хамаарах хятад сурагчдын унших чадвар хүртэл ЭЗХАХБ-ын гишүүн улсуудын дунджаас илүү гарчээ.

**БЭЭЖИН, ШАНХАЙ, ЖЯНСУ, ЖӨЖЯН МУЖИЙН СУРАГЧДЫН МАТЕМАТИК БОЛОН БУСАД ШИНЖЛЭХ УХААНЫ УР ЧАДВАР ТУС БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН УЛСУУДЫНХААС ИЛҮҮ БАЙГАА НЬ ТОДОРЛОО.**

БНХАУ-ын “сургуулиудын өнөөгийн сургалтын чанар нь

маргаашийн эдийн засгийн хүч чадлын баталгаа” хэмээн ЭЗХАХБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Анхель Гурриа үнэллээ.

Тус байгууллагаас дэлхийн 79 улсын 600 мянган сурагчийн дунд явуулсан PISA судалгаа нь сургалтын чанарыг сайжруулах ажил зарим тохиолдолд боловсролд зориулж буй төсөв хөрөнгөөс огт шалтгаалдаггүйг харуулав. Ялангуяа, сүүлийн арван жилд бага, дунд сургуулийн зардлыг 15 гаруй хувиар нэмсэн ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад байдал түвэгтэй байна.

“PISA судалгаа анх эхэлсэн 2000 оноос хойш ЭЗХАХБ-ын гишүүн ихэнх улсад сурагчдын ур чадвар сайжраагүй, харин ч гутрам үзүүлэлттэй яваа” гэж Гурриа анхааруулав.

Засгийн газраас боловсролд их хөрөнгө зардаг зарим улсад хүртэл сурагчийн амжилт өөрөөс нь хамаарч байна. ■

## "Супер" гахай бүтээх өрсөлдөөн

Кристин Сервандо

Бээжингийн хаяа дэрлэн орших, цайз аятай аварга ферм доторх ягаан, хар гэх мэт олон арван гахай жихүүн хүйтнийг ажрах ч үгүй тэжээлээ идээд дугжирцгаана. Туршилтын эдгээр гахай умард Хятадын хүйтэн өвлөөс биеэ хамгаалж, дулаанаа зохицуулах онцгой гентэй юм.

Судлаач Жао Жяньгуо гахайн ДНХ-д “суулгасан” энэ ген нь БНХАУ-д болон дэлхийн бусад улс дахь өрсөлдөгч лабораториудад ид өрнөж буй супер гахай бүтээх генийн инженерчлэлийн олон арван жишээний ердөө ганц нь. Африкийн гахайн чичрэг өвчин дэлхийг донсолгосонтой уялдан хүнсний аюулгүй байдлыг хангах, тэжээвэр гахайг амьд байлгах явдал амин чухал болсон юм.



“Эрдэмтдийн шийдвэрлэх гол асуудал бол гахайг илүү эрүүл чийрэг болгох” хэмээн Бээжин дэх Хятадын Зоологийн Хүрээлэнгийн чадварлаг 20 судлаач, шинжээчийг ахалж буй, гахайн геномын судалгаагаар дэлхийд супер од болоод буй 45 настай Жао тайлбарлав.

Хятадын амбийц хөдөө аж ахуйн мал адгууснаас хэдийн хол давсан. Тус улсын олон

арван лабораторид ажилладаг эрдэмтэд онцгой чадвартай хүнсний болон эслэг үр тариа хөгжүүлэхээр АНУ, Европтой өрсөлдөж байгаа төдийгүй мутац үүсгэдэг өвчнийг анагаах, дархлал хомсдлын вируст тэсвэртэй болгох үүднээс хүний генд засвар оруулах зэрэг зарим туршилт дэлхий нийтийн шүүмжлэлд өртсөн юм.

Дэлхийн шилдэг мэдлэг, технологид суралцуулахаар хилийн чанадад илгээсэн Жао шиг эрдэмтдийг эх орондоо эргэн ирмэгц нь Хятад улс үйлдвэрлэлийн аварга том ажиллах нөхцөлөөр хангаж өгдөг. Нийт 4,000 толгой генийн засвартай гахайг агуулах багтаамжтай Жаогийн ферм аюулгүйн хяналтын гурван давхар хамгаалалтай.

Генийн засварын технологиор “өнөөдөр Хятад тэргүүлж байгаа” хэмээн бүр 1996 онд Долли хонийг клоны аргаар гаргаж авсан Эдинбургийн их сургуулийн харьяа Рослины хүрээлэнгийн эрдэмтэн, 47 настай Саймон Лиллико тайлбарлаж байв. Хятад

судлаачид ген засварын хэрэгсэл ашиглан хөгцөнд тэсвэртэй буудай, цагдаагийн булчин шөрмөслөг нохой, ноолуур сайтай ямаа хөгжүүлэх туршилт явуулж байжээ. “Шинжлэх ухаанд хятадуудын зарцуулж байгаа хөрөнгө, мөнгөний хэмжээнд бид дөхөж ч үл дийлэх өнөө үед хийж буй зүйлдээ ухаалаг хандах шаардлагатай”-г тэрбээр анхааруулсан юм. ■

## Авто үйлдвэрлэгчид 80 мянган ажлын байрыг үгүй хийнэ

Кристоф Раувальд

Дэлхий даяар эрэлт буурч, технологи өөрчлөгдөж буйтай уялдан зөвхөн өнгөрсөн долоо хоногт Daimler AG болон Audi компани бараг 20 мянган ажлын байр танаж, автомашин үйлдвэрлэлийн салбарын хамгийн таагүй жил өндөрлөх дөхлөө.

Bloomberg News-ийн бүрдүүлсэн статистикаас үзвэл, автомашины үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлдэг гол найман үйлдвэрлэгч ирэх хэдэн жилд ажлын байраа 80 гаруй мянгаар цомхотгох гэж байна. ХБНГУ, АНУ, Их Британид илүү халгаатай тусах цомхотгол хурдтай хөгжиж буй бусад эдийн засгийг ч хамарч, үйлдвэрлэлийн хэмжээ буурах төлөвтэй.

Өнгөрсөн оны турш ажлын байраа үй олноор цөөлсөн General Motors Co, Ford Motor Co, Nissan Motor



Со-гийн эгнээнд ХБНГУ-ын авто үйлдвэрлэгчид нэгдэж эхэлсэн нь энэ. Худалдааны зөрчил, тарифын улмаас зардал ихсэж, хөрөнгө оруулалт саарсан нөхцөлд авто үйлдвэрлэгчид цахилгаанжуулалт, автомат жолоодлого, захиалгат үйлчилгээний эринд нийцүүлэн ажиллах хүчээ дахин хуваа-

рилцгааж байна. IHS Markit-ын тооцоогоор, дэлхийн авто үйлдвэрлэгчид энэ жил 88.8 сая ширхэг хөнгөн тэрэг, ачааны машин үйлдвэрлэх гэж байгаа нь үйлдвэрлэл жилийн өмнөхөөс зургаан хувиар буурах үзүүлэлт юм.

Авто үйлдвэрлэлийн салбарт

хамгийн олон хүн ажиллуулдаг БНХАУ-д ч борлуулалт муудсантай уялдан цомхотгол өрнөв. Олон тэрбум ам.долларын алдагдал хүлээж, Нью-Йоркийн биржид хувьцааных нь үнэ унасаар буй, цахилгаан машин үйлдвэрлэгч NIO Inc есдүгээр сарын байдлаар ажиллах хүчээ 20 хувиар цөөрүүлсэн төдийгүй дахин 2000 ажилчнаа халахад бэлтгэж байна.

“Суларсаар буй дэлхийн зах зээл автомат жолоодлоготой машин бүтээх судалгаа, хөгжүүлэлтийн зардлаа хэдийн ихэсгэчихсэн үйлдвэрлэгчдийн ашиг, орлогод хүнд дарамт учруулна” хэмээн Bloomberg Intelligence-ийн шинжээч Жиллиан Дэвис тайлбарлав.

Ажлын байраа алдахгүй гэсэн ажилчдын тэмцэл ч эрчээ авлаа. GM-д цагаар ажилладаг 46 мянга гаруй ажилчин энэ намар 40 хоногийн ажил хаялт зарласан нь тус компанийн сүүлийн хагас зуун жилийн түүхэнд тохиолдоогүй үзэгдэл болсон. Эсэргүүцлийн дүнд

бүр жилийн өмнө хаахаар шийдсэн, АНУ дахь дөрвөн үйлдвэрийн ердөө нэгийг нь үлдээхээр тохиролцсон билээ.

Daimler, Porsche, эд анги нийлүүлэгч Robert Bosch GmbH-гийн төв оффист байрладаг ХБНГУ-ын Штутгарт хотод ажлын байр цөөлж, үйлдвэр хаахыг эсэргүүцсэн 15 мянга орчим хүний жагсаал 11 дүгээр сарын 22-нд болов. ■

**Зардал ихсэж, хөрөнгө оруулалт саарсан тул үйлдвэрлэгчид ажиллах хүчээ дахин хуваарилцгааж байна.**





# 996.000₮



БҮХ НИСЛЭГТ ХОЁР ШИРХЭГ ТЭЭШ ҮНЭГҮЙ

 333 999

ХОИЖОЛ





# 25 жилийн дараа хүрээд ирсэн аавтайгаа хамт амьдрах нь буруу юу



“Засгийн газрын мэдээ” сонин мэргэжлийн сэтгэлзүйчидтэй

хамтран зөвлөгөө өгч байна. Энэ удаа сэтгэлзүйч Ц.Шинэдолгор уншигчдаас ирсэн асуултад хариуллаа. Хэрэв танд сэтгэл зүйн тулгамдсан асуудал байвал манай сонинд хаяглан ирүүлээрэй.

Г.Санжааханд, ЗГМ сонин

## НӨХРИЙГ МААНЬ БУЛААЧИХААД НАМАЙГ ДОРМЖИЛСОН

-Миний нөхрийг булааж жирэмсэн болчихоод намайг элдвээр доромжлоод байна. Би нөхрөөсөө албан ёсоор салж, хүүхдийн мөнгө авахаар тохиролцсон ч сүүлийн хэдэн сар өгсөнгүй. Тэгсэн чинь нөгөө хүүхэн нь “Би хүүхдээ өөрөө өсгөсөн. Хуучин нөхрөөсөө юу ч аваагүй. Чи ч бас тэгэх хэрэгтэй” гэсэн. Би яах учраа олохгүй байна?

-Тэр эмэгтэй хүүхдийг ааваас нь салгаж, харилцаа холбоог

нь тасалъя гэсэн зорилготой бололтой. Ингэж дураараа ашилж байгаа нь та их хүлцэнгүй байгаагаас үүдэлтэй. Тиймээс хүүхдээ аавтай нь уулзуулж байх хэрэгтэй. Мөн хуулийн дагуу тогтоолгосон мөнгөн тэтгэмжийг авах ёстой. Тэр бүсгүй таны нөхрийн сонголт учраас сонголтыг нь хүндэтгэхийг хичээж, заавал хүйтэн хөндий байх хэрэггүй. Ямар ч асуудал үүссэн зөвөөр харилцахыг зөвлөө. Мөн өөрөө өөрийгөө өөрчилж, хөгжүүлээрэй.

## МАНАЙ ААВ, ЭЭЖ ХҮҮХДИЙГ МИНЬ ҮРЧИЛЖ АВАХ ГЭЭД БАЙНА

-Би хоёрдугаар курсэд байхдаа хүүхэдтэй болж, хоёр нас хүртэл нь нөхөртэйгөө түрээсийн байранд амьдарсан. Хамт байх тусам таарч тохирохоо больж салахаар шийдэв. Одоо хүүхэд маань манай эцэг, эх дээр байдаг. Гэтэл манай эцэг, эх үрчилж авна гээд байна. Би яах вэ?

-Хүүхдээ төрснөөс хойш хамт байсан болохоор харилцаа холбоог нь шууд салгана гэдэг хэцүү. Гэхдээ нөхрөөсөө салсан, хүүхэд нь аав ээжийгээ тоохгүй болсон гэж үзээд ээж, аав чинь

үрчилж авах гэж байгаа бол танд өөр амьдрал зохиоход амар болох байх. Таны өөрийн эцэг, эх учраас хүүхдээсээ хөндийрч, холдохгүй нь мэдээж. Тэгэхээр аав, ээжтэйгээ сайн ярилцаж байж шийдвэр гаргаарай.

## ЭЦЭГ ӨӨРТЭЙ ДҮҮДЭЭ ӨӨРИЙН МЭДЭЛГҮЙ МУУХАЙ ААШ ГАРГАДАГ

-Найман жилийн өмнө ээж маань дахин гэрлэж, би дүүтэй болсон. Гэвч би эцэг өөртэй дүүдээ өөрийн мэдэлгүй муухай ааш гаргадаг. Үүнээс болж уур амьсгал таагүй болж, ээж минь сэтгэлээр унадаг. Би үүнийг анзаарч мэддэг хэрнээ биеэ барьж дийлэхгүй байна. Яавал дээр вэ?

-Хүн бусдаас ямар харилцаа хандлага хүлээнэ, өөрөө эхлээд тийм байх хэрэгтэй. Гэр бүлийн орчин, уур амьсгал өөрөөс чинь болоод таагүй байгааг мэдэж байна гэдэг өөрчлөх боломж байгааг харуулж байна. Хэрвээ эсрэгээрээ мэдэхгүй байсан бол асуудал илүү хүнд байх байсан. Тиймээс энэ зангаа зассанаар хувь хүнд ямар их өөрчлөлт авчрах, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал хэрхэн өөрчлөгдөх,

ээждээ сэтгэлийн тайвшрал амар амгаланг үүсгэж болох талаар илүү нухацтай бодохыг зөвлөж байна. Тэгээд аль болох биеэ барьж, асуудалд нааштай хандаж, зөв боловсон харилцаарай.

бүр өөр хандана. Тиймээс эхлээд өөрийнхөө бодлыг өөрчлөхийг зөвлөө.

## ГЭРЛЭХ ГЭТЭЛ АМЬДРАЛ ТААРУУ ГЭЭД ЗӨВШӨӨРСӨНГҮЙ

-Би одоо 22 настай. Найз залуутайгаа гэрлэх гэтэл хадмын талынхан манай гэр бүлийн амьдрал тааруу гэдэг шалтгаанаар зөвшөөрөхгүй байна. Доромжлолыг тэсвэрлэж чадаагүй болохоор хайртай хүнээсээ салсан. Цаашид энэ явдал давтагдвал яах ёстой вэ?

-Салсан нь зөв шийдвэр гэж бодож байна. Учир нь тэр хүмүүсийн хандлага, юмыг үзэх үзэл тийм байна гэдэг нь таны хайртай хүн бас тийм байж болох магадлалтай. Гэхдээ бүх хүн тийм биш учраас санаа зовох хэрэггүй. Та өөрийн сул талаа бодоод хэтэрхий их айдаст автаад байна. Тиймээс энэ бүхнийг мартаж хэрэгтэй. Ирээдүйн нөхөр чинь таны амьдралтай суухгүй учраас өөрөө өөрийгөө өөрчилж хөгжүүлээрэй. Өөрийгөө өөр талаас нь харуулж, хүчтэй, боловсролтой байж чадвал хүн

## ГЭНЭТ ГАРЧ ИРСЭН ААВ МИНЬ ГЭРТ ХЭРҮҮЛ ҮҮСГЭХ БОЛЛОО

-Аав маань намайг арван настай байхад хаяад явсан ч 25 жилийн дараа буцаад ирэхэд нь бид хүлээж авсан юм. Охин хүүхэд эцгээ харж хандах ёстой гэсэн эхийнхээ захиасыг санаад гомдож явдаг ч гэсэн хүлцэхээр шийдсэн. Гэтэл архи ууж гэрт хэрүүл үүсгээд байх боллоо. Ингэлээ гээд гудамжинд гаргалтай биш, яах вэ?

-Хүн алдаж, онож болно. Аав тань гэнэт ирж, гэр бүлийн амьдралд чинь ороход таатай, таагүй мөчүүд их байсан байх. Тиймээс эхлээд аавтайгаа сайн ярилцах хэрэгтэй. Аав тань анх архи уудаг байсан бол та хүлээж авахгүй байсан байх. Гэнэт архи ууж эхэлсэн бол тэр хүнд ямар нэгэн шалтгаан байна гэсэн үг. Тэгэхээр засаж авах хэрэгтэй. Аавынхаа сул талыг бус танай гэр бүлтэй хамт амьдарвал ямар давуу талтай, нөмөр нөөлөгтэй байхыг бодож үзээд, ярилцсаны эцэст шийдвэр гаргаарай. ■

## СОНЖОО

# Хайр гэдэг таны хувьд ...



1. Төгс хүн гэж хорвоод байдаггүй. Тиймээс та хайртай хүнийхээ ямар алдааг уучилж чаддаг вэ?

А. Хардалт - 0  
Б. Мартамхай зан ба цаг барьдаггүй явдал - 3

В. Залхуу, чихэртэй зүйлийг хэмжээ хязгааргүй иддэг зуршил - 6

2. Таны найз болзоонд хоцорч ирлээ. Гэхдээ цэцэгтэй, эсвэл ямар нэг бэлэгтэй ирвэл юу гэж бодох вэ?

А. За энэ хүн надаас нэг юм нууж байна даа - 3

Б. Надад их хайртай юм байна - 6  
В. Аргагүй л сайн сэтгэсэн байна шүү - 0

3. Хайрыг юутай уялдаатай гэж үздэг вэ?

А. Эрх мэдэл - 6  
Б. Энхрийлэл - 0  
В. Халамж - 3

4. Сэтгэлтэй хүнтэйгээ болсоны дараа сэтгэл санаа чинь

ямар байдаг вэ?

А. Би түүнд яг галзуурсан мэт дурладаг - 0

Б. Миний сэтгэл санаа маш өөдрөг байдаг - 3

В. Гэртээ харих цаг боллоо - 6

5. Мөнгө гэдэг үг таны ойлголтоор ихэвчлэн ямар үйл үгтэй уялдадаг вэ?

А. Хамгийн сайхан зүйлүүдийн нэг - 3

Б. Үргэлж мөнгөтэй байхын тулд - 6

В. Зүгээр л мөнгөтэй байх - 0

6. Та хайртай хүндээ сексийн сэдвээр янз бүрийн юм ярихыг зөвшөөрдөг үү?

А. Яагаад үгүй гэж - 6

Б. Үгүй, энэ нь таалагддаггүй - 0

В. Хүссэн хэмжээгээрээ ярьж

болно - 3

7. Ирээдүйн гэр бүлээ төсөөлбөл хамгийн түрүүнд ямар бодол орж ирэх вэ?

А. Хорвоогийн бүх юм сайн сайханд хүргэдэг - 3

Б. Хуримын бөгж бол цагдаагийн гавтай адил эрх чөлөөг минь булааж авна - 0

В. Ганцаар байх сайхан ч хоёулаа байх бүр сайхан - 6

8. Хэрэв таны мөрөөдөл ямар нэг эд зүйл болж хувирвал тэр нь юу байх вэ?

А. Зөөлөн тоглоом - 0

Б. Гоёлын зүүлт - 6

В. Мэдэхгүй - 3

## ХАРИУЛТ

0-21 оноо: Та хайртай хүнтэйгээ романтик байхаасаа илүү найз нөхдийн харьцаатай байхыг эрмэлздэг.

24-33 оноо: Хүнд бүх сэтгэлээрээ татагддаг бөгөөд дурласан хүн чинь танд яг адилхан сэтгэл гаргах ёстой гэж итгэдэг. Хайр гэдэг таны хувьд хамгийн нандин зүйл.

36-48 оноо: Та зүгээр л дурламтгай хүн биш. Гэхдээ хүнийг өөртөө галзууртал дурлуулж чаддаг хүн. ■



# Багачуудын гоёл “Бүүвэй” брэнд

Гадаадад амьдардаг монголчууд ах дүүсээрээ дамжуулан захиалж авахуулдаг болсон



Гэрэл зургийг Ж.Гэрэлчулуун

Б.Гандолгор, ЗГМ сонин

**М**онголчууд хүүхдээ үндэсний хувцсаараа гангалах дуртай болжээ. Энэ нь хүүхдийн дээл хантаазны эрэлт, хэрэгцээнээс харагддаг талаар энэ төрлийн үйлдвэрлэл эрхлэгчид хэлж байна. Бид энэ удаагийн “Би үйлдвэрлэгч” буландаа хүүхдийн дээл, хантаазны “Бүүвэй” брэндийг сурвалжиллаа. Баянзүрх дүүргийн жижиг, дунд үйлдвэрийн байрны хоёрдугаар давхарт бизнес инкубатор төв байх аж. Энэхүү төвд голдуу эмэгтэй үйлдвэрлэгчид ажиллаж байна. Оёдолчин бүсгүйчүүдээ дүүргийнх нь Жижиг, дунд үйлдвэрийн хэлтсээс дэмжиж, хямд түрээстэй ажлын байраар хангасан нь энэ аж. Тус байрны томоохон талбайд “Бүүвэй” брэндийн үйлдвэрлэл өрнөдөг. Оёдлын машины дуу тасралтгүй дуугарч, шавилхан биетэй залуухан бүсгүй торго “амилуулж” суулаа. Өдгөө 27 настай М.Дарамрэнчин бол “Бүүвэй” хүүхдийн

брэндийг санаачлагч юм. Тэрбээр барилгын ландшафтын архитекторч мэргэжил эзэмшсэн хэдий ч түүнийг сургуулиа төгсөх үед барилгын салбар уналтад орж, ажлын байр олоход амаргүй байжээ. Ажилласан зарим газар нь цалингаа өгөх өгөхгүйтэй байсан нь цаашдаа мэргэжлээрээ ажиллах хүсэл сонирхлыг нь мохоосон аж.

Нэгэн хувийн байгууллагад ажиллахын хажуугаар цахим ертөнцтэй нөхөрлөж, интернэтээс хүүхдийн бойтог нэхэх аргыг сурсан нь түүнд хүүхдийн брэнд үйлдвэрлэх анхны алхам болжээ. Ингээд хэсэгтээ хүүхдийн бойтог нэхэж зарсан нь овоо эрэлттэй болж, өөрийн гэсэн үйлдвэрээ нээх урам зориг өгсөн байна. Ганц бойтог гэлтгүй үүнийгээ нярайн дээлтэй хослуулан

урлаж интернэтээр захиалга авч, хүргэж өгдөг болов. **Эхэндээ “Уранхолбоо” нэртэй социал хуудас нээж, түүгээрээ захиалга авч хүргэдэг байсан бүсгүй өнөөдөр үйлдвэрээ өргөжүүлж, нэр төрлийг нь олшруулж, загвараа ч нэлээд шинэчилжээ.** Ингээд таван хүнийг ажлын байраар хангаж, борлуулалтын сувгаа ч шийдэж чаджээ. Үйлдвэрлэсэн бараагаа “Ард онлайн шоп”-той хамтарч захиалгаар хүргүүлдэг болсон. “Бүүвэй” брэнд өнөөдөр олон нийтэд нэлээд танигджээ. Гадаадад амьдардаг монголчууд ах дүүсээрээ дамжуулан захиалж авахуулдаг болсон гэж тэрбээр онцолсон юм.

Биднийг сурвалжлахаар очсон өдөр гэхэд АНУ-аас захиалсан тухайг дуулгаж нэгэн эмэгтэй дээл худалдаж авлаа. Мөн БНСУ-д ажиллаж, амьдардаг монголчуудаас чамгүй захиалга ирдэг аж. Японоос ч гэсэн захиалга ирдэг хэмээсэн юм. Иймээс эрэлт болоод зах зээл боломжийн хэмээн ярьж байлаа. **0-2 хоёр настай хүүхдүүдэд зориулсан “Бүүвэй” брэндийн загвар тун чамин. Салдаг малгайтай, энгэр дээрээ хоёр жижиг халаастай. Дээлийг орчин үеийн гоёмсог**

**загвараар үйлдвэрлэж буйгаараа тэрбээр сайрхсан юм.**

Хиймэл үсэн болон зуны нимгэн, хурганы арьсан дотортой гээд сонголт сайтай. Бас болоогүй дээр нь тусгайлан аравнайлуулсан хонх, явуугаар чимэглэсэн байх юм. Яагаад ч

**“БҮҮВЭЙ” БРЭНДИЙН ХҮҮХДИЙН ДЭЭЛ ХИЙМЭЛ ДОТОРТОЙ НЬ 80-90 МЯНГАН ТӨГРӨГИЙН ҮНЭЭР ЗАРАГДДАГ. ХАРИН ХУРГАНЫ АРЬСАН ДОТОРТОЙ ДЭЭЛИЙГ 200-250 МЯНГАН ТӨГРӨГӨӨР ХУДАЛДДАГ АЖ. ХУРГАН ДОТОРТОЙ БОЙТОГ 35000, ХАНТААЗЫГ НЬ 50000 ТӨГРӨГӨӨР ХУДАЛДАН АВАХ БОЛОМЖТОЙ.**

юм явуу хэмээх зөөлөн биет амьтны эгдүүтэй ясан хуягийг монголчууд хүүхдэдээ зүүж өгдөг дом бий. Энэ нь хар, цагаан хэл амнаас хамгаалдаг гэдгийг хүүхдийн брэнд үйлдвэрлэгч маань онцолсон. Ингэж сэтгэлээ шингээж урладаг болохоор хүмүүс манай хувцсыг сонгох дуртай хэмээн тэрбээр ярилаа.

Эднийх хажуудаа арьс элддэг цех байгуулсан байна. Хурганы арьсыг өөрсдөө элдэж, дээл, хантааз, бойтог оёхоор арай хямд гардаг аж. М.Дарамрэнчин Баянхонгор аймгийн Гурванбулаг суманд төрж өссөн бөгөөд хэсэг хугацаанд орон нутагтаа үйлдвэрлэл явуулж, сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдан бизнесээ өргөжүүлжээ. Ингээд зогсохгүй шилдэг брэнд бүтээгдэхүүний шагналыг ч хүртсэн байна. Тэрбээр “Анх үйлдвэрлэл эхэлж байхад нярайн үндэсний хувцас төдийлэн элбэг байгаагүй. Гэтэл сүүлийн үед хүмүүс урладаг болжээ. Тиймээс бусдаас ялгарахын тулд шинэ загвар гаргах шаардлага тулгарсан. Нэг шинэ загвар гаргахаар маргаааш нь яг дуурайгаад хийчихдэг болсон тул дахиад өөр шинэ санаа олж хийх хэрэгцээ гардаг” хэмээж суулаа. Шинэ жил дөхөж буй учраас санта загвар хийхээр зэхэж буйгаа дуулгасан юм. Санта загвар нь цагаан эмжээртэй, улаан нэхмэл оймс, мөн ийм өнгийн малгайтай хосолсон багц аж. М.Дарамрэнчингийн мөрөөдөл их. Цаашдаа 21 аймагт салбараа байгуулах зорилго өвөртөлж яваагаа ч нуусангүй. Учир нь орон нутгаас ихээхэн захиалга ирдэг аж. Бас загвараа ч нэлээд шинэчлэх шаардлага бий гэдгийг хэлсэн бөгөөд дан ганц үндэсний хувцас бус европ загвартай хослуулан хийх уран санаа түүний сэтгэлд бий аж. 3-4 насны хүүхдэд зориулсан





Уйлдвэрлэсэн бараагаа “Ард онлайн шоп”-той хамтарч захиалгаар хүргүүлдэг болсон байна.



Хиймэл үсэн болон зуны нимгэн, хурганы арьсан дотортой гээд сонголт сайтай. Бас болоогүй тусгайлан аравнайлуулсан хонх, явуугаар чимэглэсэн.

малгайтай нөмрөг хийсэн нь борлуулалт сайтай байжээ.

2015 онд албан ёсоор оюуны өмчийн гэрчилгээгээ гардан авчээ. “Бүүвэй” брэндийнхэн аль болох хүүхдийн биед сөрөг нөлөөгүй материал аар үйлдвэрлэхийг чухалчилдаг аж. Иймээс даавуу сонгохдоо БНСУ-ын стандартад нийцсэн материал сонгодог байна. Бөөсрөхгүй, шороо тоос татахгүй, хүүхдийн биед харшил өгдөггүй, амьсгалдаг гээд солонгос даавуу урд хөр-

шийн метрийн барааг бодвол давуу талтай байдаг гэж ярилаа. Даавууны чанарыг баталгаажуулахын тулд лабораторийн шинжилгээнд өгдгөө ч сонирхуулав. М.Дарамрэнчин “Сүүлийн гурван жил манай барааны үнэ хэлбэлзээгүй. Гадуур нэлээд өндөр үнэтэй байдаг юм билээ. Бид аль болох зах зээлд нийцсэн үнээр борлуулахыг чухалчилдаг. Захиалагчтайгаа зөвлөлдөж,

загвар эсгүүр гээд бүх зүйлийг өөрөө гардаж хийгээд оёдолчдоо өгдөг” гэж ярилаа.

Урд хөрш рүү гаргах гарц бас харагдсаныг тэрбээр яриандаа дурдсан юм. Өвөрмонголд хурганы арьсан дотортой дээл эрэлттэй байдгийг тэрбээр судалж мэджээ. Иймээс дараагийн жилүүдэд экспортод гаргах зорилго тавьсан байна.

Хүүхдийн дээл шаглаач маань “Манайх баривч бойтгийг хосоор нь хийдэг болохоор бусдаас ялгардаг. Хийж бүтээх гэж зорьж, зүтгэж байгаа болохоор бэрхшээл тохиолдлоо ч даван туулахыг боддог. Энэ бол миний дуртай ажил. Хүн дуртай ажлаа хийхээр түр зуурын бэрхшээлийг хэцүү гэж шантардаггүй юм. Даваад гарвал ард нь амжилт угтдаг гэж бодоод сэтгэл өөдрөг байдаг шүү” хэмээн инээмсэглэж зогсов. “Авьяс нэг хувь, хөдөлмөр 99 хувь” гэдэг болохоор хичээж



ажиллавал хэзээ нэгэн өдөр амжилтад хүрнэ гэж тэрбээр нэмж хэлсэн юм.

“Бүүвэй” брэндийн хүүхдийн дээл хиймэл дотортой нь 80-90 мянган төгрөгийн үнээр зарагддаг. Харин хурганы арьсан дотортой дээлийг 200-250 мянган төгрөгөөр худалддаг аж. Хурган дотортой бойтог 35,000, хантаазыг 50,000 төгрөгөөр худалдан авах боломжтой.

Монголчууд баяр ёслолоор үндэсний хувцсаараа гангардаг болсон нь хүүхдийн үндэсний хувцасны зах зээлийг тэлж байна. Өдгөө хүүхдийн хувцасны зах зээлд 12 тэрбум гаруй төгрөг эргэлддэг гэсэн судалгаа бий. Бага ч гэсэн өөрсдөө хувцсаа үйлдвэрлээд байвал гадагш урсах вальютыг дотооддоо шингээх сайн талтай. Энэ мэтээр хүн бүр хөдөлмөрч, өрх бүр үйлдвэрлэгч болбол улс орноо хөгжлийн зам руу хөтлөх нь дамжиггүй. ■



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

**Тендер шалгаруулалтын нэр:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй XVII.1.27. “Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах.

**Тендер шалгаруулалтын дугаар:** ТӨБЗГ-2019/XVII.1.27

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь эрх бүхий тендер оролцогчдоос:** Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй XVII.1.27. “Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000.00 (Тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

2016, 2017, 2018, 2019 оны аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 50 хувиас доошгүй хэмжээний ижил төстэй ажлын гэрээ байгуулж ерөнхий гүйцэтгэгчээр

ажилласан байна.

Дараах тусгай зөвшөөрөл шаардлагатай: Барилга, хот байгуулалтын яамны **ЗТ-4.1, ЗТ-6.1, ЗТ-6.2, ЗТ-6.3, ЗТ-6.4, БА-4.1, БА-6.1, БА-6.2, БА-6.3, БА-6.4, БА-8.1.** /Түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгчид нь гүйцэтгэх ажил үүргийнхээ дагуу тусгай зөвшөөрөлтэй байна./

Тендерийн хамт дараах дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийн баталгааны дүн: 140,000,000.00 (Нэг зуун дөчин сая) төгрөг.

Тендерийн материалд цахим тендерийн баталгааг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем тендерийн баталгаа гаргагч арилжааны банкны мэдээллийн сангаас тендер оролцогчийн тендерийн баталгааны талаарх мэдээллийг шалгана.

Тендерийг **2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 10.30 цагаас** өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 11.00 цагт** нээнэ.


Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө-16А, Засгийн газрын IX байр, Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 267435, 267023 Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn)**





# Ж.Энхбаатар: Цуглуулга бол дурсамжийн илэрхийлэл

Очсон орныхоо онцлогийг илэрхийлсэн, гоёмсог түлхүүрийн оосор авдаг

О.Даваасүрэн, ЗГМ сонин

**З**орчсон газар, аялсан орноосоо түлхүүрийн оосор цуглуулах, мөн мод тарих сонирхолтой нэгэн бол Ж.Энхбаатар. Уул уурхайн компанид хариуцлагатай алба хашдаг тэрбээр сонирхлоо амьдралынхаа хэв маяг болгож чаджээ. Тэрбээр өдгөө 2000 орчим мод, бут тарьж ургуулсан бөгөөд 300 орчим түлхүүрийн ховор, нандин оосор цуглуулсан нь сонирхол татна. Тиймээс “Амьдралын хэмнэл” буландаа Ж.Энхбаатарыг онцолж, ярилцлаа.



**-Таны цуглуулга их сонирхолтой, өвөрмөц юм. Өнгө, загвар давтагдаагүй ийм олон оосрыг хэдий хугацаанд цуглуулсан бэ. Яагаад заавал түлхүүрийн оосор цуглуулах болов?**

-Одоогоос дөрвөн жилийн өмнө БНСУ-д аялж байхдаа тухайн улсын хэв маягийг илэрхийлсэн түлхүүрийн оосор худалдан авч байлаа. Тухайн үед цуглуулга болгон өргөжүүлнэ гэж төсөөлөөгүй. Авчирсан оосрыг харсан хүмүүс их шохоорхож байсан нь сайхан сэтгэгдэл төрүүлсэн. Мөн хөгжлийн бэрхшээлтэй нэгэн хүү намайг ийм сонирхолтой болоход нөлөөлсөн юм. Тэр хүү өөрөө маш олон чамин түлхүүрийн оосор цуглуулсан байв. Түүний цуглуулгыг хараад би их бахархаж, өөрийн цуглуулгаа өргөжүүлэх хүсэлд автсан.

**-Ажлын өрөөнийг нэг ханыг бүхэлд нь түлхүүрийн оосроор чимсэн нь содон харагдаж байна. Хүмүүс цуглуулгаа саванд хийгээд, “хав дардаг” байтал та өөрийн хоббиг бусдад таниулж буй нь бахархмаар. Энд нийт хэчнээн оосор байна вэ?**

-Одоогоор 300 орчим түлхүүрийн оосор бий. Цуглуулж эхэлснээс хойш ажлын хамт олон, найз нөхөд, гэр бүлийнхэн минь түлхүүрийн оосор их бэлэглэдэг болсон. Мөн

би гадагшаа явах бүртээ очсон орныхоо онцлогийг илэрхийлсэн, гоёмсог түлхүүрийн оосор авдаг. Энэ хана бол миний хувьд дурсамжийн цуглуулга минь. Бид үргэлж зургийн цомгоо нээж, сайхан аяллынхаа талаар дурсаад байдаггүй шүү дээ. Харин түлхүүрийн оосор үргэлж нүдэнд тусаж, сэтгэлийн таашаал мэдрүүлдэг төдийгүй тухайн цаг үед очсон мэт дурсамж, мэдрэмжийг сэргээдэг онцлогтой. Тиймээс ажлын өрөөндөө цуглуулгаа байрлуулсан нь эрч хүч авч, энергиэ цэнэглэхэд их дэм болдог. Анх гурван жилийн өмнө ажилд ороход энэ хана мэдээллийн самбар байсан бол одоо цуглуулгынх болсон.

**-Сүүлийн үед хүмүүс хэт хэрэглээнээс татгалзаж, минималист амьдралын хэв маягийг эрхэмлэх болсноор эд цуглуулдаг хүмүүс цөөрч буй мэт санагддаг. Харин та эл үзлийн эсрэг хандлагатай хүн үү?**

-Тийм ээ, би минималист төрлийн хүн биш. Хүн дуртай зүйлээ л хийж, аз жаргалыг мэдрэх хэрэгтэй гэж боддог. Ер нь ямар нэг хандлага, хэв маягийг өөртөө хүчээр суулгах гэж хичээх нь өрөөсгөл санагддаг.

**-Та багаасаа эд, материал цуглуулах сонирхолтой байсан уу, өөр цуглуулга бий юу?**

-Ихэнх хүн нийгмийн шаардлагын улмаас ажил, амьдрал гээд асар завгүй байдаг. Ийм их ачаалалтай амьдарч буй хүнд ямар нэг сайхан мэдрэмж төрүүлж, сэтгэлийн амар амгаланг мэдрэх хүчин зүйл зайлшгүй байх хэрэгтэй гэж боддог. Тиймээс би өөрийгөө хөглөхийн тулд түлхүүрийн

оосор цуглуулах болсон. Одоогоор надад өөр цуглуулга байхгүй. Гэхдээ чөлөөт цагаараа мод тарьж, арчлах хоббитой. Шувуун фабрикт байдаг 0.5 га газартаа 2000 гаруй мод, бут тарьж, ургуулсан. Үүнийгээ мөн хөдөлмөрөөрөө бүтээсэн цуглуулга маань гэж боддог. Ер нь ямар ч хоббид цаг, мөнгө зарцуулж байж хүссэн үр дүндээ хүрдэг. Тухайлбал, тарьсан модоо ургуулахын тулд манай гэр бүлийнхэн чөлөөт цагаа зориулж, багагүй зардлыг ч үүндээ зарцуулдаг. Түлхүүрийн оосор цуглуулахад ч цаг, мөнгө шаарддаг. Хамгийн гоёмсгийг нь хайж сонгох, дахин давтагдашгүй, өвөрмөц хэв маягийг олох гээд нэлээн сэтгэл, зүтгэл гаргадаг.■



# Б.ХҮСЭЛТҮВШИН:

Хүссэн нь авч, хүсээгүй нь үлддэг



✍ Г.Санжааханд, ЗГМ сонин

Өнгөрсөн сард зохиогдсон Бодибилдинг фитнесийн 11 дэх удаагийн ДАШТ-ий алтан медалийн эзэн Б.Хүсэлтүвшинг энэ удаагийн “Гоо сайхан” буландаа онцолж байна. 15 настай байхдаа “Монголын хамгийн гоё биетэй залуу болно” хэмээн хүсдэг байснаа тэрбээр нуугаагүй юм. Олон бүсгүйн нүдийг булаасан түүний төгс сайхан бие бялдрыг шагших нь олонтаа. Б.Хүсэлтүвшин одоо “Хүсэл” брэндээ хөгжүүлэхэд түлхүү анхаарч буй бөгөөд шинэ оны эхээр олны хүртээл болгохоор зорьж байна.

- **Биеийн жин:** 90 кг
- **Биеийн өндөр:** 180 см
- **Биеийн харьцаа:** 126:80:115
- **Биеийн хамгийн дуртай хэсэг:** Хөл
- **Орд:** Хумх
- **Төрсөн он сар өдөр:** 1987.01.24
- **Нүдний өнгө:** Бор
- **Үсний өнгө:** Бор
- **Төгссөн сургууль:** Их засаг их сургууль
- **Төрсөн газар:** Улаанбаатар хот
- **Нууц авьяас:** Дуулах, бүжиглэх, жүжиглэх
- **Ажил:** “Хүсэл” брэнддээ төвлөрөн ажиллаж байна. Мөн спортын зөвлөхөөр ажилладаг.
- **Идэх дуртай хоол:** Бүх төрлийн хоол, ялангуяа, шинэ ногоо, өндөгний цагаантай стейк
- **Дуртай сүрчиг:** Chanel blue
- **Хобби:** Ууланд алхах, сэлэх зэрэг бүх төрлийн спортыг хобби болгосон
- **Зорилго:** Бүх нийтийн эрүүл мэндэд хэрэгтэй мэдээлэл өгдөг, зөвлөдөг нөлөөлөгч болох
- **Сонсох дуртай дуу:** Би монгол хүн
- **Дуртай брэнд:** “Хүсэл” брэнд
- **Үзэх дуртай кино:** 37-р точка
- **Дуртай орчин:** Байгалийн нам гүм орчин
- **Баримталдаг зарчим:** Хэлсэндээ байж, зорьсондоо хүрэх
- **Дуртай баяр:** Шинэ жил, төрсөн өдөр
- **Багын хоч:** Хүска
- **Бухимдлаа тайлах арга:** Спортоор хичээллэх
- **Өглөөг хэрхэн эхлүүлдэг вэ:** Өглөөний мэнд өнгөт орчлон минь гэж эхлүүлдэг дээ
- **Хэлэх дуртай үг:** Хүссэн нь авч, хүсээгүй нь үлддэг





Олхонуд Баярхүү, Профессор

# Найрамдлын магтан дуулал, геополитик судлал


Атаархаагүй л бол энэ талаар амаа үд

**Б**и бүр ойлгохгүй мунгинаад байна. Уг нь найрамдлыг магтан дуулах, геополитик судлах нь тэс өөр, тэс хөндлөн зүйл баймаар. Гэтэл хольж хутгаад Монгол-Оросын харилцааг, Оросын геополитикийн миний судлал руу чиглүүлэн намайг яллах дон нийгэмд мэр сэр байх юм. Монгол-Зөвлөлтийн ба Монгол-Оросын найрамдлыг магтан дуулсангүй гэж нүд үзүүлэх юм. Эрдмийн хүрээнд ярьж байна шүү, би.

“Хөршөө мууллаа”, “Хөршөө муулж гадаад бодлого ярилаа”, “Та бичиж нийтлэхдээ хойд хөршийг муулахгүй байвал сайнсан, анхаараарай”, “Хоёр хөршөөсөө салж нүүчихгүйгээс хойш хөрштэйгээ сайн сайхан байх хэрэгтэй” хэмээн ярьж үглэдэг, зөвлөдөг хүн байна. Бүр Солонгосын хойгийн асуудал хэлэлцсэн хурал дээр над руу чиглүүлэн дайрч байлаа. “Ким Чен Ун Владивостокт очоод гавьтай юм болсонгүй, ОХУ Солонгосын хойгийн хэрэг явдлаас бараг хасагджээ. Орос болон Япон улсыг “Зургаан талт яриа хэлэлцээ”-нээс бараг хасчихлаа гээд хурцхан хэлтэл Монгол-Оросын найрамдлыг магтан дуулагч нар заалнаас цухалдаад хашхиралдав.

МУИС-ийн ОУХДС гэж байхад хамт багшилж, нэг тэнхимд хамт ааглаж явсан (тэр үедээ Сөүлд суралцаад ирсэн, үлэмж өрнөжсөн) нэг эрдэмтэн найз маань хэд хэдэн хурал дээр “Хөршөө мууллаа” хэмээн надтай ам мууриж “сайн найз”-аа болих дээрээ тулаад байна. Ямар тахил нь буруу өрөгдчихсэн юм бүү мэд. Эсвэл тэгж ярихаас аргагүй болтлоо шахаанд орж, Оросын холбогдох албадаас үүрэг хүлээсэн аятай намайгаа отож байгаад “Хөршөө мууллаа” хэмээн нэхэл дагал хийх янзтай.

**Монгол-Зөвлөлтийн ба Монгол-Оросын найрамдлыг магтан дуулсангүй гэж нүд үзүүлэх юм. Эрдмийн хүрээнд ярьж байна шүү, би.**



Би хөршөө муулаагүй ээ, Оросын биетэй бодитой геополитикийг судалсаар байна. Судалгаагаа Оросын өөрийнх нь эсэргүү эрдэмтдийн лүндэгдсэнээс эшлэж байна хэмээн би мянга өчөөд Монгол-Оросын найрамдлыг “магтан дуулагч найз”-даа адлуулж дуусах нь. Хэдхэн жилийн өмнө дөө. Стратегийн судалгааны хүрээлэнгээс зохиосон хурал дээр тэр маань “Шанхайн байгууллага бол буг чөтгөр мөн. Түүнээс холуур явах хэрэгтэй” гэх маягийн үг хэлж байснаасаа шууд л

180 градус эргэж. Үгийн солиогүй л ШХАБ-д жинхлэх хэрэгтэй гээд ярьж байна. МҮОНТВ-ээр Де-факто бид хоёр цэц булаалдан мэтгэлцэж байсныг хүмүүс анзаарсан байна лээ. Салж нүүж чадахгүй хоёр хөрштэйгээ хувь заяагаа хуваалцах минь, тэр гарц суваг нь ШХАБ гээд л ярьж байв.

Төвийг сахихаас өөр гарцгүй болох вий гэсэн нийтлэлийг минь уншаад юу ч ойлгосонгүй хэмээн тэр маань гомдоллож байна лээ. Ойлгох албатай ч биш, би ойлгуулах албатай ч биш. Ойлгохгүй бол тэгээд орхино биз, цухалдах хэрэггүй. Атаархаагүй л бол энэ талаар амаа үд.

Ерөөсөө ганц логикийг ойлгохгүй байна. Эрх чөлөөт ардчиллын (ардчиллын замаар 30 жил замнаж яваа) амтыг эдэлсэн өнөөгийн Монгол Улсад монгол хүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлынхоо төлөө шоронд суухгүй байх бүх эрхийг Үндсэн хуулиараа хуульчилсан гэдгийг дээрх нөхөд нэг лухаж өгөхгүй нь. Заавал намайг Монгол-Оросын найрамдлыг “магтан дуулагч” болсонгүй хэмээн нүд үзүүлэх нь адаглаад Үндсэн хуулийн үзэл санаанд харш үзэгдэл биш үү. Явж явж геополитик судлалаа орхи гээд байгаа юм уу.

Монгол-Оросын найрамдлыг “магтан дуулагч” нөхдөд бол ОХУ-ын ярьсан, хийсэн, үйлдсэн бүхнийг үг дуугүй магтан дуулж дэвэргэж, үйл хөдлөл бүрийг

нь эв санааны нэгдэл хэмээн илтгэж, гомдоочих вий гэдгээс ямагт айж хулчийх уу. Оросоос зээл тусламж авч Монгол-Зөвлөлтийн үеийн найрамдлыг сэргээн бүтээн

явна) гол лоббидогч нь Польш болоод байна. Тэгвэл түрэг-лалын интеграц руу хуучин Зөвлөлтийн Өвөр Кавказ, Дундад Азийг улайм цайм лоббидогч нь Турк болчихоод байна. Польш, Турк хоёрыг бид үзэн ядах ёстой болох нээ.

Европын Холбооны жинхэнэ гишүүн, НАТО-гийн жинхэнэ гишүүн, хэрэг дээрээ пост-зөвлөлтийн ашиг сонирхлын хүрээнээс аль хэдийн гараад явчихсан Польш нь Нэгдсэн Европын бүрэн эрхт гишүүн болчихоод украин, молдав, гүрж, беларусчуудын хорыг маажиж, атаархлыг төрүүлж, Оросын нөлөөний хүрээнээс гарах чин хүслийг бадрааж байгаа бол Улаанбаатарт байгаа бид Москвагийн төлөө мянга хашхирч, мэдээллийг нь хааж, мань мэт судлаачдыг мянга гөвшөөд нэмэр байна уу.

байгуулалт хийлгэх, эс бөгөөс Орос гэдэг баавгай яаж ч мэднэ хэмээн айж сүрдэж, тэр үзэлдээ сүсэлж явах юм биз дээ.

ОХУ олон улсын харилцаанд дахин том тоглогчоор гарч ирж байгааг би огт үгүйсгээгүйгээр үл барам Сирид лалын террористуудыг номхруулсанд нь баярлан бахдаж байгаа нэгэн билээ. Туркийн Эрдоан гэх хэнээтэй нөхрийн амыг татаж байгаад нь бас баярлан баяр хүргэнэ. Африк руу эргэн орж Африкийн 20 тэрбум ам.долларын өрийг цайруулж байгаад нь ч баяр хүргэнэ.

ОХУ олон улсын харилцаанд нэр хүндгүй, соёлт ертөнцөөсөө шахуулсан, санкцад өртсөн нь яалт ч үгүй бодит үнэн. Гүрж гэдэг тусгаар тогтносон улсыг гурав хуваагаад тавьчихсан, гүржүүд үүнийх нь төлөө Оросыг зүхэж харааж, тэр хэрээр “Оросын ертөнц”-өөс салж, өрнөдийн ертөнцийн эд эс болж хувираад, дотроо цэгцрээд босож ирснийг нь би яасан ч муу хэлж чадахгүй. Энэ бол Монгол-Оросын найрамдалд огт хүртээлгүй, геополитикийн тоглолт, түүнд өгч буй үнэлгээний асуудал юм.

Оросын олон улсын нэр хүндийг алж байгаа Польштой бид харилцаагаа зогсоогоод, Орос-Польшийн зөрчил дээр бид ямагт Оросын талд зогс хэмээн албадах нь ямар логик вэ. Евроинтеграц руу Украин, Молдав, Гүрж, магадгүй Беларус, Арменыг (энэ хоёр улс хэзээ мөдгүй Европын интеграц руу

**БИ ХӨРШӨӨ МУУЛААГҮЙ ЭЭ, ОРОСЫН БИЕТЭЙ БОДИТОЙ ГЕОПОЛИТИКИЙГ СУДАЛСААР БАЙНА.**

Украин гэдэг улс, Украины ард түмэн Монголд ямар гэм хийсэн болоод бид Киев дэх төр-засгийг нь Москвагийн өнцгөөс муулж байх ёстойг Монгол-Оросын найрамдлын дуучдаас ам асуумаар санагддаг юм. Украин гэдэг тусгаар тогтносон улсыг гурав хуваагаад тавьчихлаа. Дорнод нутагт нь цэрэг ба хүнд зэвсгээ байрлуулан байлдууллаа. Оросыг дагах уу, Европыг дагах уу гэдэг дээр сонголт хийснийг нь хашраагаад Крымын хойгийг нь өөртөө хавсарган нэгтгэж, Дорнод Украиных нь хоёр мужийг тоглоомын БНУ болгоод байж байгааг даян дэлхийн 200 улсаас ганц Монгол л дэмжиж эв санааны нэгдэлтэй байх ёстой гэх нь эрүүл ухаан мөн үү. Оросууд өөрсдөө ам алдааж хэл халтираад холбоотон гэгчихээд байдаг Хятад нь хүртэл, бүр СССР-т хамт байсан эдүгээ ТУХН гэдэгт хамт байгаа, Евразийн эдийн засгийн холбооны гишүүд нь хүртэл Гүрж, Украин дээр Оросын талд зогсохгүй байгааг юу гэж үзэх вэ. Энэ нь тухайн улсаас ОХУ-тай тогтоосон найрамдалт харилцааны үйлс биш байгаа биз дээ. ■





# CO2-ыг хуримтлуулан ашиглавал том бизнес болж магадгүй

Хүлэмжийн хийн ялгаруулалт жилд нэг хувиар нэмэгдсээр 2018 онд 37 гигатоннд хүрсэн

**Н**үүрстөрөгчийн давхар ислийг хураан хуримтлуулж, түлш, барилгын материал гэх мэт арилжааны бүтээгдэхүүн болгох нь дэлхийн хэмжээнд шинэ бизнес болж магадгүй гэж Калифорни болон Оксфордын их сургуулийн судлаачид дүгнэжээ. Ийм зорилт хэрэгжвэл хүлэмжийн хийг багасгахад ихээхэн тус болох талтай. Nature сэтгүүлд нийтлэгдсэн тайланд дурдсанаар энэхүү судалгаанд нүүрстөрөгчийн давхар ислийг ирээдүйд ашиглах боломж ба өртөг зардлыг 10 янзаар авч үзсэн байна. Үүнд түлш, химийн бодис, хуванцар, барилгын материал, хөрсний менежмент болон ойн аж ахуйд ашиглах боломжийг судалжээ.

Түүнчлэн олборлодог түлшийг шатааснаас үүссэн асар их утаа буюу агаар мандлаас хүлэмжийн хийг аж үйлдвэрийн аргаар ялгаруулан авсан CO2-ыг ашиглахад голлон анхаарчээ. Уг асуудлаар сүүлийн судалгаанаас ахисан алхам нь судлаачид фотосинтез биологийн аргаар нүүрстөрөгчийн давхар ислийг ялгаж авах боломжийг хайсан явдал юм. Судалгаанаас үзэхэд ашиглалтын нэг шугамаар жилдээ 0.5 гигатонн хүлэмжийн хийг агаар мандалд гаргалгүй хурааж авах боломжтой аж. (1 тонн = 1000 кг, гигатонн нь 1 тэрбум тоннтай тэнцэнэ).

**ДЭЭД ХУВИЛБАРААР ТООЦВОЛ ЖИЛДЭЭ 10 ГИГАТОНН НҮҮРСТӨРӨГЧИЙН ДАВХАР ИСЛИЙГ АШИГЛАХ БОЛОМЖТОЙ БА ОНОЛЫН ХУВЬД 1 ТОННЫН ӨРТӨГ НЬ 100 АМ.ДОЛЛАР БАЙНА.**

Дээд хувилбараар тооцвол жилдээ 10 гигатонн нүүрстөрөгчийн давхар ислийг ашиглах боломжтой ба онолын хувьд 1 тонны өртөг нь 100 ам.доллар байна. Гэхдээ судлаачдын тайлбарласнаар уг хийг ашиглах хэмжээ ба зардал салбар бүрт өөр өөр байх юм. Калифорнийн их сургуулийн доктор, тайлангийн нэг зохиогч Эмили Картер “Бидний танилцуулсан анализ нүүрстөрөгчийн давхар ислийн ашиглалт уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хийх тэмцлийн нэг хэсэг байж болохыг харууллаа. Гэхдээ засаг захиргаа ба санхүүгийн шат шатны шийдвэр гаргагчид бодлогоо өөрчилж, салбаруудад зах зээлийн хөшүүрэг бий болгосон цагт л хэрэгжих боломжтой. Энэ бол асар тулгамдсан

асуудал бөгөөд өөрчлөлт хийх цаг маш бага үлдсэн” хэмээв. Уур амьсгалын асуудлаар Засгийн газар хоорондын зөвлөлийн тооцоолсноор XXI зууны туршид дэлхийн дулаарлыг цельсийн 1.5 хэмээс дээш гаргалгүй барихын тулд агаар мандлаас 100-1000 гигатонн нүүрстөрөгчийн давхар ислийг зайлуулах ёстой. Өнөөгийн байдлаар олборлодог түлшний шатаалтаас үүссэн хүлэмжийн хийн ялгаруулалт жилд нэг хувиар нэмэгдсээр 2018 онд 37 гигатоннд хүрчээ.

Тайлангийн нэг зохиогч, Оксфордын профессор Камерон Хепборн “Нүүрсний ялгаруулалтыг тэглэж, уур амьсгалыг тогтворжуулахад хүлэмжийн хийг зайлуулах нь амин чухал. Бид ялгаруулалтыг түргэн багасгаж чадахгүй байгаа тул агаар мандлаас нүүрстөрөгчийн давхар ислийг татаж авах шаардлагатай. Засгийн газрууд ба компаниуд энэ чиглэлээр хөдөлж эхэлэн боловч хангалттай хурдан ажиллахгүй байна. Тэрээр “Нүүрстөрөгчийн давхар ислийг хурааж хуримтлуулж ашиглах нь ялгаруулалтыг бууруулах нэг түлхэц болохоос гадна олборлодог түлшийг орлуулах үйл явцад дэмжлэг үзүүлнэ” гэж дүгнэсэн байна.

Үүний зэрэгцээ энэхүү зөөлрүүлэх стратегийн шинэ технологи уур амьсгалд хэрхэн нөлөөлөхийг нарийн судлах шаардлагатай байгаа аж. ■

## Шавжны тоо таамагласнаас илүү цөөрч байна

Арван жилийн өмнөхтэй харьцуулахад олон бус нутагт шавжны төрөл зүйл гуравны нэгээр цөөрсөн гэж эрдэмтэд тооцоолжээ. Мюнхений их сургуулийн эрдэмтдийн тэргүүлсэн олон улсын судлаачдын багийнхан тайландаа ийм дүгнэлт хийв. Идэвхтэй тариалангийн талбайн ойролцоох хээр талд ийм үзэгдэл газар авсан боловч ой болон хамгаалалттай газар ч мөн хамрагдсаныг энд дурдсан байна.

**Германы нутагт 25 жилийн өмнөхөөс хавьгүй**



**цөөн шавж үлдсэнийг олон баримтаар нотолсон.**

Гэхдээ өмнөх судалгаануудад шавжийн биомасст голлон анхаардаг байсан бол төрөл зүйл, тухайн бүлэгт нөлөөлсөн байдал тодорхой бус байв. Мюнхений их сургуулийн доктор Себастьян Сиболд хэлэхдээ “Ийм олон төрөл зүйлд нөлөөлснийг саяхан нотоллоо” гэжээ. 2008-2017 оны турш хийсэн судалгааны тайлан Nature сэтгүүлийн сүүлийн дугаарт нийтлэгдсэнээс үзвэл эрдэмтэд 300 газраас сая шахам шавж цуглуулж, бараг 2700 төрөл зүйлийн тоо цөөрч байгааг нотолсон байна. Уг судалгаанд бичсэнээр ойд амьдардаг шавжны биомасст 2008 оноос 40 хувиар цөөрсөн аж. ■

## Ургамал жижгүүддээ туслан хамт цэцэглэдэг нь нотлогдлоо

Байгалийн ургамлууд үргэлж өрсөлддөг гэх уламжлалт онолыг сөрсөн шинэ нээлт хийжээ. Хатуу ширүүн уур амьсгалд гүйцэд томорсон ургамал жижгүүддээ тусалж, хамтдаа ургадгийг судалгаагаар тогтоосон байна. Ургамлын амьдралыг бүхэлд нь хамруулсан анхны

Энэхүү нээлт хатуу ширүүн уур амьсгалтай бүсийн менежментэд ач холбогдолтой аж. Судалгаанд оролцсон доктор Росио Перес-Барралес “Уулын орой, элсэн манхан мэтийн газрын нүцгэн хөрсөнд соёолж суулгахдаа том ургамлын дэргэд байрлал



судалгаанаас үзэхэд сөрөг орчинд ургамлууд дөнгөж соёолж буй жижиг ургамлыг нөмөрлөн өөрсдөө сайн ургадаг үзэгдэл байдаг аж. Испанийн Валенси хотын Цөлжилтийн төв, Портсмутын их сургуулийн хамтарсан судалгааг Испанийн өмнөд нутгийн экологийн цөлд явуулжээ.

сонговол амжилтад хүрэх боломж илүү. Бидний хийсэн гайхалтай нээлт бол нэгэнт томорсон ургамал халамжлагчийн үүрэг гүйцэтгэж соёолжийг халхалдаг явдал. Ийм ургамал ургамал өөрөө ч дангаар ургаж буй том ургамлаас олон цэцэг навч гаргадаг” хэмээн өгүүлэв. ■



➡ Mortgage loan benefits 95,000 citizens

Mongolia has provided housing mortgages to 95,000 borrowers since 2013, a senior official of the Mongolian Mortgage Corporation (MIC) said.

➡ Mongolia was chosen as vice president of UNESCO's program

The 40th session of the UNESCO General Conference was held in Paris, France in late November.

➡ Mongolian Prime Minister holds official talks with Prime Minister of the Russian Federation

# President partially bans 2020 Budget Law

The Budget Law increased 2020 budget deficit to MNT 2.07 trillion



✍ Amina U., ZGM Daily

**O**n December 3, President of Mongolia Battulga Khaltmaa sent an official letter to Parliament Speaker Zandanshatar Gombojav to veto 2020 Budget Law, specifically ban Law on Advocacy and several other laws submitted with it.

The official letter said, "The Budget Law increased 2020 budget deficit

to MNT 2.07 trillion, and has many other disadvantages and risks to the country's economic and social life."

"Social insurance fees will have increased by 2 percent in 2020, posing a risk to increase pressure on the lives of people," it included

The President has banned investment of the budget partially, the funding of 174.2 billion MNT from increased social insurance, and the regulations of amendments to the Law on Future Funds wholly. ■

Image by Batsaikhan.S

## ZGM: QUOTE

### Yoon Seok Hyun: Mongolia's pension system remains vulnerable

With regard to the President's partial ban on the 2020 budget law, ZGM talked to the IMF Resident Representative in Mongolia, Yoon Seok Hyun. The IMF says it's too early to comment on the ban, but does not completely deny possibilities for further discussion on cancelling the increase of social contribution rate.

**-The President of Mongolia on Tuesday issued a partial ban on the 2020 budget law, namely on the expected increase of the social contribution rate. What's the IMF's reaction to this? Does this change any of the expectations IMF previously had?**

-Yes, we heard about the

President's reaction to the 2020 budget. We are now looking into the details. It is too premature to offer our views on this.

**-There's growing resistance from the working population and the private sector about increasing the social security contribution rate. Has the Mongolian government approached the IMF about looking back on this change? If the Government has or if it does in the future, would there be a possibility to negotiate cancelling the increase?**

-In the context of the IMF-supported program agreed in 2017, the Mongolian authorities committed to increase the social security contribution rate by 5

percentage points over three years. In making this commitment, the authorities aimed to strengthen the sustainability of public finances, particularly with respect to the pension system (of which deficit is expected to increase in the near future with increase of pension payments exceeding of collected pension premiums). The pension system in Mongolia plays a crucial role of income redistribution via its support for lower- and middle-income Mongolians. To continue to play such a role, it must be adequately financed.

Fiscal revenues have overperformed since the start of the IMF-supported program, but Mongolia's pension system remains vulnerable. Without increases in

**IN THE CONTEXT OF THE IMF-SUPPORTED PROGRAM AGREED IN 2017, THE MONGOLIAN AUTHORITIES COMMITTED TO INCREASE THE SOCIAL SECURITY CONTRIBUTION RATE BY 5 PERCENTAGE POINTS OVER THREE YEARS.**

the pension system is projected to rise from 2 percent of GDP in 2016 to 6 percent in 2030 and 11 percent in 2050, according to an analysis by the World Bank. This rising deficit primarily reflects an aging population and policy changes enacted in 2012 and 2017 adversely impacted the pension system design and incentives. Even the proposed increases in the contribution rate will only partially offset the projected increase in the pension deficit. If this deficit is unaddressed, the government will either need to raise taxes, cut other spending, or bear the burden of further increases in Mongolia's already high debt.

**The full exclusive interview will be published on the next issue. ■**

the contribution rate, the deficit in



## ZGM: HIGHLIGHTS

### ■ POLITICS

During his official visit to Russia, Mongolian Prime Minister Khurelsukh Ukhnaa holds official talks with Prime Minister of the Russian Federation D.A. Medvedev on December 3. Following the meeting, a signing ceremony of 12 agreements on bilateral cooperation between Mongolia and Russia took place.

Minister of Defense Enkhbold Nyamaa pays an official visit to Japan at the invitation of his counterpart, Japan's Minister of Defense Kono Taro. Sides exchanged views on regional security issues, deepening the bilateral strategic partnership and expanding cooperation in the field of defense.

### ■ ECONOMY

Share prices of Baganuur JSC, listed on MSE tier-II, falls below 10 years lowest. The stock dropped by MNT 150 or 13.64 percent to a closing price of MNT 950.

Top 20 index falls 1.81 percent, to 18,520.09 points. MSE A index decreases 3.36 percent, to 8,491.85 points. MSE B index drops 1.06 percent, to 7,645.56 points. Market cap stands at MNT 2,49 trillion.

### ■ SOCIETY

The Mongolia Immigration Agency reports that the type O Mongolian visas for foreign citizens arriving upon invitation by NGOs and international humanitarian organizations to be issued online.

On December 3, the Asian Development Bank (ADB) and Changemaker economic journalists club co-organized a workshop under the theme Air pollution and Housing Provision.

## MARKETS

# Mortgage loan benefits 95,000 citizens

Mongolia has provided housing mortgages to 95,000 borrowers since 2013, a senior official of the Mongolian Mortgage Corporation (MIC) said on Tuesday.

**GOM HAS BEEN STRIVING TO IMPROVE AIR QUALITY IN ULAANBAATAR BY TAKING VARIOUS MEASURES, INCLUDING BANNING THE BURNING OF RAW COAL FOR DOMESTIC USE. HOUSEHOLDS STARTED TO USE ENHANCED COAL BRIQUETTE FROM MAY 15, 2019.**

The government of Mongolia started implementing a mortgage loan program in 2013 to increase the affordability and accessibility of apartments for urban residents, particularly young families and those living in ger

districts.

"Providing housing mortgages at a rate of 8 percent is also part of the government's efforts to reduce air pollution in the country, especially in the capital city Ulaanbaatar," Zorig Munkh-Orgil, first deputy CEO of the MIC, said at a workshop on air pollution and housing. A total of 95,000 borrowers have benefited from the housing program. Over 90 percent of them are residents of Ulaanbaatar.

Air pollution is a major challenge for Ulaanbaatar, where over 800,000 residents, half of its population, live in the city's ger districts, with no running water, central heating or sewerage systems.

Ger residents use stoves and burn raw coal and other flammable materials to cook and keep warm during the region's winter, a practice believed to be responsible for an estimated 80 percent of the air pollution in the capital city.

GoM has been striving to improve air quality in Ulaanbaatar by taking various measures, including banning the burning of raw coal for domestic use. Households started to use enhanced coal briquette from May 15, 2019. ■



Image by Gerelchuluun.J

## POLITICS

# Mongolia was chosen as vice president of UNESCO's program

The 40th session of the UNESCO General Conference was held in Paris, France in late November. During the conference, Mongolia was chosen as Vice President of the International Programme for Social Change Management (IPSCM), included in the Asia-Pacific group members along with Bangladesh and Thailand.

Intergovernmental Council and Bureau of IPSCM composed of

35 member states elected by UNESCO's General Conference, taking into account the need to ensure implementation of the program and evaluate program activities.

The Council is responsible for policy-making, guiding the planning and the implementation of the Program, approving priorities of the Program, reviewing and assessing achievements on the basis of implementation and

evaluation reports on the projects and defining the basic areas requiring increased international cooperation, reviewing ways and means whereby Member States might participate more effectively in the International Program for the Development of Communication, approving an appropriate system of financing for the Program in order to secure the necessary resources for the benefit of those requesting assistance from the

Program.

In the framework of the program, Mongolia implemented several projects in 1996-1998, 2001, 2006-2007, 2015 and 2017. In 2019, the Parliament of Mongolia, the Mongolian Academy of Sciences and the Mongolian National Commission of UNESCO jointly organized Reducing Social Inequality: Knowledge to Government Policy seminar in Ulaanbaatar. ■

## MINING

# People under 40 make up most of mining sector workforce

In terms of the age group, 18-25-year-old people account for 26 percent of the mining sector's workforce and people between 26-40 are 53 percent. In other words, people under 40 years old account for about 80 percent of the total employees in the mining sector, the Mineral Resources and Petroleum Authority of Mongolia (MRPAM) reported.

Thus, 25 percent of the mining sector workers are engineers and technicians, 9 percent are administration personnel, and 35 percent are technical operators. This estimate is based

on information from 263 mining reports submitted to the Minerals and Petroleum Authority in 2018.

Mongolian specialists account for 96 percent of the total workers in the sector while four percent are foreign specialists. The number of foreign workers reached 2,060 by the end of 2018. The number of mining employees has now dropped from about 16,000 to 11,000 by the end of last year following Shaft 2 construction completion of Oyu Tolgoi, the largest employer in the underground mine construction. ■






Т.Намуунболор, ЗГМ сонин

**Х**айрттайгаа болзохдоо хамтдаа хийж болох сонирхолтой зүйлсийн санааг хосууддаа санал болгоё. Кино үзэж, оройн хоол идэх нь шинэ мянганы залууст хэдийн улиг болжээ. Хайртай хүнээ баярлуулж, сайхан сэтгэгдэл төрүүлэхэд энэ зөвлөгөө тус болох нь гарцаагүй.

**Жич:** Зөвхөн хосууд гэлтгүй ганц бие хүмүүс ч доорх санаануудыг туршаад үзээрэй. Заяаны хань зам дээр гэдэг дээ.

#### ЭКСТРИМ БОЛЗОО

Адал явдлыг эрэлхийлдэг, амьдралдаа шинэ, содон зүйл туршиж үзэхийг хүсдэг хүмүүст энэ болзоо хамгийн тохиромжтой. Ханан хаданд авирч, агаарын замаар бууж, цэвэр агаарт явган алхаж



экстрим аяллын гайхамшигийг мэдрээрэй. Extreme Mongolia-аас 45 мянган төгрөгийн аялал зохион байгуулдаг. Автобус унаанаас эхлээд өдөр болон оройн хоол багтсан тул санаа зовох зүйлгүй. Түүнчлэн усанд шумбах, шүхрээр буух гэхчлэн олон төрлийн аз туршсан сонирхолтой үйлчилгээ бий. Магадгүй та спортод дуртай бол давуу талаа харуулах сайхан боломж биш гэж үү.

#### ХӨГЖИЛТЭЙ БОЛЗОО

Хүүхэд насаа дурсаж, хөдөлгөөний дутагдлаас ангижрахаас гадна цагийг зугаатай өнгөрүүлж болох хөгжилтэй болзоог санал болгоё. Монголын анхны "Үсэрдэг трамполин парк"-д тоглож, стресс ядаргаагаа мартаарай. Хүссэнээрээ үсэрч харайж, хүүхэд шиг хөгжилдөх нь та хоёрын болзоог огтхон



## Болзоогоо хэрхэн сонирхолтой болгох вэ

бүлээрээ энэ болзоог хийвэл тун сонирхолтой. Баярын уур амьсгал ойртсон энэ өдрүүдэд гацуур модныхоо чимэглэлийг хайртай, дотнын хүмүүстэйгээ хамт хийж яагаад болохгүй гэж. Шавар урлалаар бүтээл хийхдээ том хүн 40 мянга, хүүхэд 30 мянган төгрөгийн төлбөр төлдөг. Керамик арт студийг зорин очиж, нэг өдрийг бүтээлчээр өнгөрүүлэн хүссэн бүтээлээ



ч уйдаахгүй. Үсэрч харайж, ядартлаа тоглосныхоо дараа болзоот бүсгүйгээ зайрмагаар дайлбал бүр ч янзтай. Тус төвд тоглоход нэг цаг нь 15 мянга, 30 минут нь 10 мянган төгрөгийн төлбөртэй бөгөөд Zaisan Hill худалдааны төвд байрладаг.

#### БҮТЭЭЛЧ БОЛЗОО

Шинэхэн хосууд гэлтгүй гэр

урлаж, гэрээ чимэглээрэй. Анх удаа болзож буй хосууд нэг нэгэндээ бүтээлээ дурсгаж ч болох хамгийн шилдэг болзоо шүү.

#### РОМАНТИК БОЛЗОО

Сансар огторгуй, од гариг, эрхсийг ойроос харж үдшийг өнгөрүүлэх романтик болзоог хэрхэвч мартаж болохгүй. Үзэсгэлэнт оддыг ширтэнгээ халуун кофе ууж, хайртай хүнтэйгээ дотно яриа өрнүүлэх шиг сайхан мэдрэмж гэж үгүй. "Гоё аялал" компанийн зохион байгуулдаг тус аялал 30 мянган төгрөгийн төлбөртэй бөгөөд оройн хоол, автобус унаа, музей болон од дурандах хураамж зэрэг бүх зардал багтдаг. Өөрийн ордны од болон дуртай гараг эрхсийг дурандан бие биеийнхээ нүдэнд гэрэлтэх одыг улам бүр гялалзуулаарай. ■



### МЭДЭХЭД ИЛҮҮДЭХГҮЙ Болзооны тухай сонирхолтой баримтууд

•Онлайн болзооны салбар жилд 1.8 тэрбум ам.доллар олдог

•Болзоо дасгалжуулагчийн зах зээл АНУ-д жилд 260 сая ам.доллараар хэмжигддэг.

•Хэрэв эмэгтэй хүнд болзоо сонирхолгүй санагдвал харц тулгарахаас зайлсхийх, инээмсэглэхгүй байх, мөрөө хавчих, хөлөө товших, эсвэл хоосон ширтэх зэрэг үйлдэл хийдэг.

•Эрэгтэйчүүдийн 40 орчим хувь нь эмэгтэй хүнтэй анх удаа уулзахдаа өөртөө итгэлгүй байдаг.

•Сургууль, коллеж, кофе шоп, худалдааны төв зэрэг газарт сээтэгнэхэд хамгийн тохиромжтой. Учир нь эдгээр газарт бусадтай уулзахад илүү нээлттэй байж чаддаг аж. Харин хамгийн муу байршил бол ресторан, кино театрууд юм.

•Хамтран ажиллагсадтайгаа болзоонд явсан 10 хос тутмын дөрөв нь гэрлэх шийдвэр гаргадаг.



ЭНЭ ӨДРИЙН ЗУРХАЙ

# Хилэнцийн ордынхон хайр дурлалд одтой байна



**Хонь /III.21-IV.19/**

Өнөөдөр олон сонирхолтой сонголтыг амлаж байна. Хууль шүүхийн асуудал сэтгэл ханамжтайгаар шийдэгдэх бололтой. Ажил мэргэжил, хувийн амьдралын хооронд тэнцвэрээ олох нь хэцүү байж магадгүй. Гэхдээ яг одоо түр зуурын байдлаар аргацаахаас өөр аргагүй болно. Хүнтэй харилцах нь таны эвийг олох чадварыг сорих бололтой. Зарим хүнд ярихаас илүү тэвчих нь гол онооны түлхүүр байна.



**Мэлхий /VI.22-VII.22/**

Өнөөдөр хүчтэй байх үүрэг хариуцлага дуудах болно. Хэрэв хийж дуусгах ажил байгаа бол барьж авахад бэлэн бай. Өөрөөс тань илүү эрх мэдэлтэй хүнтэй хийх тохиролцоо хүнд байна. Тэдний тавьж байгаа шаардлагатай зөрөлдөх гэсний хэрэггүй. Хэлээ хазаад зааврын дагуу хөдөл. Өнөөдрийн од гараг таныг тушаал өгөх хүн биш байх болно гэж байна.



**Жинлүүр /IX.23-X.22/**

Олон нийтийн өмнө эвгүй нөхцөл байдалтай тулгарна. Зарим эдлэх эрхийнхээ төлөө тэмцэх хэрэг гарна. Иймэрхүү асуудалд ялагч болон үлдэх нь баталгаатай биш боловч зөв юм хийсэн гэдгээ мэдэж байвал зүрх сэтгэлээ дагаж, гарах үр дүнд зовох хэрэггүй. Бясалгалаар хичээллэснээр иймэрхүү асуудлуудыг энгийн, дарамт багатай даван туулж чадна.



**Матар /XII.22-I.19/**

Хувийн болон гэр бүлийн асуудал зонхилно. Хайр дурлал анхаарлын төвд байж, улам бүр бэхжих болно. Хосуудын хувьд гайхалтай зочид буудлын өрөө захиалах нь хайр дурлалын цаашдын хандлагад хэрэгтэй. Баяраас өмнө жингээ хасахыг хүсч буй хүмүүс амжилт олно. Та эрүүл мэндийн талаасаа ч бодсон хэд хоног хоолны дэглэм баривал амжилттай байна.



**Үхэр /IV.20-V.20/**

Бичиг цаасны ажил, гарын үсэг зурах зэрэг нь ихээхэн цаг авна. Чухал баримт бичигтэй харьцахдаа хариуцлага өндөр байлга. Зарим ажил уйтгартай санагдах боловч анхаарал дээд зэргээр шаардаж байгааг сануулья. Тэнцвэрт байдла олохын тулд хийх ёстой зүйлээ дууссаны дараа илүү адал явдалтай ажлыг өөртөө бэлэглэж болно.



**Арслан /VII.23-VIII.22/**

Өнөөдрийн үйл ажиллагаанд оролцох нь олон төрлийн санаа, боломж өгөх болно. Таньд өөрчлөлт хийх боломж байна. Та үйл явдлын гол тоглогч нь бай. Бардам байхаасаа ичсэний хэрэггүй. Өөрийгөө бэлтгэн өрсөлдөөн гэж юу байдгийг харуул. Алдартнууд ч эхлэхдээ өөрсдөө эргэлзэж байсан гэдгийг сана. Санаа зовсон байдлаа хойш нь тавьж, үйл ажиллагаандаа чин сэтгэлээсээ оролц.



**Хилэнц /X.23-XI.22/**

Эрч хүчээр дүүрэн өдөр. Од эрхэс шинэ бүтээлч үйл ажиллагаа, хайр дурлалд таатай нөлөө үзүүлнэ. Мөн эцэг эх хилэнцүүд хүүхдүүдээ ивээлээ тусгаж байна. Өнөөдөр үр хүүхдээ тордож, зөв хүн болох ёс суртахуун суулгахад сайн өдөр. Бүтээлч хүмүүс олон нийтийн ажилд оролцох боломжтой. Та хэт их үүрэг амлалттай байхаас санаа битгий зов. Ийм ажлууд эрүүл чийрэг байдлыг сэргээх болно.



**Хумх /I.20-II.18/**

Жил бүрийн энэ үед эмнэлгийн үзлэгт хамрагд. Эрүүл мэндээ сайн эмнэлэгт шинжлүүлэх нь эрүүл энх байхын үндэс болно. өөртөө зориулах цагтай байх нь зугаа цэнгэлд зарцуулах Тогтмол мөнгийг хэмнэнэ. Түр зуурын асуудалтай тулгарч магадгүй тул түрүүлж үг хэлэхээсээ өмнө дотроо тооцоол. Чухал хүмүүстээ цаг гарга.



**Хамтатгах /V.21-VI.21/**

Дулаан харилцаа холбоо хүслээ биелүүлэх боломж олгоно. Өөрийн замаар явах гэсэн хүслийн тань эргэн тойронд зарим нэг сэтгэлийн түгшүүр гарч ирнэ. Зорилгодоо хүрэх нь маш чухал ч танд бусдын дэмжлэг хэрэгтэй тул туслалцаа авахаас бүү зайлсхий.



**Охин /VIII.23-IX.22/**

Тайван биш байдал таны бодол санаанд саад болж, шийдвэр гаргахад дарамт болно. Ухаангүй үйлдэл хийхээс өмнө суугаад сайн эргэцүүлж бод. Хэрэв ямар нэгэн айдас байвал дүгнэлт хийхийг хичээ. Хэрэв та шударга байвал таныг жоолоодож байсан ямар ч сэтгэлийн хөдөлгөөнүүд алга болох болно.



**Нум /XI.22-XII.21/**

Шинэ төлөвлөгөө хэрэгжүүлж, амьдралд тань байсан аливаа саадыг арилгаж чадна. Гараг эрхэсийн нөлөөгөөр бусад хүмүүсээс өөрийн хүсч буй зүйлээ гуйхад нааштай байх болно. Хувийн хүсэл эрмэлзэл бодит болно. Албан бус үйл ажиллагаа ганц бие залууст хөгжилтэй байна.



**Загас /II.19-III.20/**

Од эрхэсийн байрлал танд сайнаар нөлөөлөх бололтой. Таны бүтээлч авьяас дүүрэн байна. Мөн өөрийгөө илэрхийлэх сайхан завшаан гарна. Таны харилцааны чадвар өөрийн хэрэгцээгээ дээшлүүлэх зорилгын ахиц дэвшилд томоохон нэмэр үзүүлж магадгүй. Өнөөдөр хөрөнгө орлогоо мэдээлэхдээ болгоомжтой бай.

ДОРНЫН ЗУРХАЙ

## Үс засуулбал өвчин өчүүхэн ирнэ



**Наран ургах, шингэх:**  
08:24-17:02

**Үс засуулбал:**  
Өвчин өчүүхэн ирнэ  
**Барилдлага:** Хүчин төгсөх  
**Шүтэн барилдлага:** Сэрэхүй  
**Суудал:** Гал

**Аргын тооллын арванхоёрдугаар сэрын 5, Бархасвадь гараг. Билгийн тооллын 9, Шувуун хошуут одтой, улаан хулгана өдөр.**

Өдрийн наран 08:24 цагт мандаж, 17:02 цагт жаргана. Тухайн өдөр бич жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйл эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, лус тахих, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдуулах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

			1				2			
3		4				5		6		7
				8						
9						10				
				11						
12	13					14				15
				16						
17										18

ХӨНДЛӨНГӨӨР:

1. Баригддаггүй морь
2. Монголын армийн спортын төв клуб
3. Дайчин вангийн хүчтэнүүдийн нэг шилийн сайн эр
4. Өгөөдэй хааны хүү, Их Монгол Улсын хаан
5. Лац
6. Цасны барс
7. 1918 онд Их Ионгол улс байгуулсныг зарласан өртөө хот
8. Засаг захиргааны нэгж
9. Товгор
10. Таних тэмдэг
11. Гүрэн
12. Хаврын тэргүүн сар

➔ Өмнөх дугаарын хариу 12.04

			А	Ц	Э	Г	И	Е	Н	А	А	М	И		
			В	Э	Р		Р		Н	И	Ж				
			А	Г	Э	Р	Э	Ө	Е	А	Г	Б	И		
			Г	О	Н		Н	Ө	Ж		У		Ө	Д	
			А	Т	Э	Л	Э	Э	И	Л	Ж	И	Г		Э
			М	А	И		У		Г	А	Н		О		А
									В		С				Р
															В
															Ж

БОСООГООР:

1. 1955 онд улсын баяр наадмын бөхийн барилдааныг сугалаагаар явуулахад түрүүлсэн бөх
2. Сагсуу, ойворгон
3. Мусульман шашны эзэн тэнгэр
4. Лам нарын ном гүрэмдээ хонхтой хамт хэрэглэх хэрэгсэл
5. Монгол гэрийн дээврийн дотуур барих давхарлага
6. Монголын уран зохиолын түүхэн гурван оргилын нэг
7. Есөн эрдэнийн нэг
8. Хол биш

ЗГМ: СУДОКУ

1				5				9	
5	8		4						3
		6			7				
9	6			4					
	1							6	
				2				5	8
			2					5	
7						9		2	4
	3			8					6

➔ Өмнөх дугаарын хариу

1	4	5	2	6	8	9	7	3
3	8	2	1	9	7	6	4	5
6	9	7	4	5	3	1	2	8
5	1	4	9	7	2	3	8	6
9	7	8	6	3	5	4	1	2
2	3	6	8	1	4	5	9	7
4	6	3	7	8	1	2	5	9
7	2	9	5	4	6	8	3	1
8	5	1	3	2	9	7	6	4



## КИНО ЕРТӨНЦ

# Т.Анар: “Сүүн замын сахиул” эрх чөлөө, өв соёлын үнэ цэнийг таниулна

Киноны зохиолыг дөрвөн жилийн турш боловсруулжээ

О.Даваасүрэн, ЗГМ сонин

**М**УГЖ Ц.Төмөрбаатарын хүү Т.Анарын найруулсан “Сүүн замын сахиул” кино өнөөдрөөс үзэгчдийн хүртээл болж эхэллээ. Тус кино Т.Анарын ерөнхий найруулагчаар ажилласан анхны уран бүтээл бөгөөд кино зохиолыг дөрвөн жилийн хугацаанд боловсруулжээ. Хэний ч сонирхлыг татахаар бүтээгдсэн энэхүү киноны талаар түүнтэй цөөн хором ярилцлаа.

**“Сүүн замын сахиул” киноны зураг авалтыг хэдий хугацаанд хийсэн бэ. Зохиолыг та бичсэн юм байна?**

-Кино зохиолоо 2014 онд бичсэн. Хоёр жилийн дараа зураг авалтаа эхлэх гэтэл хөрөнгө мөнгөний гачигдлаас болоод чадаагүй. Харин өнгөрсөн оноос зохиолоо шинэчлэн, найруулж, гуравдугаар сараас хойш дөрвөн сарын турш зураг авлаа. Зохиолыг хуурай ахынхаа амьдралын зарчим, зан суртахуунаас сэдэвлэн бичсэн. Гол агуулга нь эрх чөлөө, өв соёлын үнэ цэнийг таниулахад оршиж буй юм. Аливаа уран бүтээл цаг, тохироо нь бүрдэж байж үзэгчдийн хүртээл болдог гэж боддог. “Сүүн замын сахиул” киног удаан хугацаанд боловс-



руулж, одоо л үзэгчдийн хүртээл болгох гэж байна.

**-Хүмүүс таныг МУАЖ Ц.Цэгмидийн ач, МУГЖ Ц.Төмөрбаатарын хүү гэдгийг мэднэ. Үе дамжсан урлагийн авъяас жүжигчин болоход нөлөөлсөн байх. Хэзээнээс зохиолч, найруулагчаар ажиллав?**

-Би уг нь барилгын инженер мэргэжилтэй ч 2008 оноос киноны дүр бүтээж эхэлсэн. Цаанаасаа л жүжигчин мэргэжлээр ажиллахыг хүсэж,

түүндээ дурласан. Эхэндээ туслах дүр бүтээж, сүүлдээ гол дүр дээр ажилладаг болсон юм. Яг л бусад залуу жүжигчний адил урлагт хөлөө олсон. Аав, авга ах маань жүжигчин болоход нөлөө үзүүлсэн ч “надад дүр өгөөч, би ийм кинонд тогломоор байна” гэж хэлсэн удаагүй. Харин “Сүүн замын сахиул” кинонд анх удаа бие дааж, ерөнхий найруулагчаар нь ажилласан. Өмнө нь олон уран бүтээлд нэг, хоёрдугаар найруулагч хийж

байлаа.

**-Энэ киног эрх чөлөө, өв соёлын үнэ цэнийг таниулах зорилготой бүтээжээ. Сүүлийн үед уран бүтээлчид түүхэн болон улс үндэстний соёл, үнэ цэнийн талаарх сэдэвтэй кино их хийх болсон. Эдгээрээс ялгарах онцлог нь юу вэ?**

**КАЗАХСТАНД ӨНГӨРСӨН САРЫН 28-НД НЭЭЛТЭЭ ХИЙСЭН УГ КИНОГ КИРГИЗ, ОХУ, ДАГЕСТАН, УЗБЕКИСТАН, ХАЛИМАГИЙН КИНО ТЕАТРЫН ДЭЛГЭЦЭЭР ТОЛИЛУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА.**

-Бид кино зохиолдоо маш их ач холбогдол өгсөн. Ганц миний санаа, зохиолоор хийсэн бус олон судлаач, жүжигчид нийлж, өөрийн санаа, бодлыг тусгасан. Учир нь кинонд эртний болон одоо цагийг хослуулан харуулж буй. Мөн залуу хүний уран сэтгэмжээр эх орны үнэт зүйлийг таниулж, үзэгчдэд ойлгуулахыг зорьсноороо онцлогтой. ■

## “Цойлогсод” тэргүүлээ

“Интер ном” номын дэлгүүрээс долоо хоног бүрийн лхагва гарагт бестселлерээ шинэчлэн зарладаг уламжлалтай. Тэгвэл энэ удаад Д.Бүжинлхамын “Цойлогсод” хамгийн өндөр борлуулалттай номоор шалгарчээ. Тус ном “Аз хур”-ын бестселлерийн хоёрдугаарт эрэмбэлэгдэж байна. Дөрвөн долоо хоногийн турш дээгүүр байрт явсан “Энгийн Кето” шилдгүүдийн жагсаалтаас хасагджээ. Харин Г.Мөнгөний “Хадгаламж өлсөхөөс эхэлнэ” ном худалдаанд гарсан цагаасаа бестселлерт жагссаар байна. Ингээд “Интер ном”-ын шилдэг 10 жагсаалтыг хүргэе.



1. Д.Бүжинлхам “Цойлогсод”
2. Хэл Элрод “Өглөөний гайхамшиг”
3. Мишель Обама “Becoming: Миний түүх”
4. Танин мэдэхүйн карт “Орон орны туг далбаа-2”
5. Г.Мөнгөн “Хадгаламж өлсөхөөс эхэлнэ”
6. Х.Болор-Эрдэнэ “Гүйж яваа эмэгтэй”
7. Үй Хау “Цусаа худалдсан тэмдэглэл”
8. Рэйчил Холлис “Бүсгүй минь нүүрээ угаа”
9. Э.Төгөлдөр “Миний анхны 1000 англи үг”
10. Марк Мэнсон “Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг”. ■

## АРВАНХОЁРДУГААР САРЫН ОНЦЛОХ ҮЗВЭР



### ХУНТ НУУР

Энэхүү бүжгэн жүжиг балетийн урлагийн түүхнээ бичигдсэн бүх цаг үеийн хамгийн агуу бүтээлүүдийн нэг. 140 гаруй жил сонгодог урлагт хайртай үзэгчдийн сэтгэлийг татаж, эрхэмсэг нандин мэдрэмж мэдрүүлдэг онцлогтой. Оросын суут хөгжмийн зохиолч П.И.Чайковский хөгжмийг бичиж, анх Юлиус Резингер дэглэн тавьж, Оросын Их театрын тайзнаа 1877 оны гуравдугаар сарын 4-нд тоглосон түүхтэй. Өдгөө “Хунт нуур” бүжгэн жүжгийг дэлхийн олон театр өөр өөрийн хувилбараар тавьж байна. Монголд анх 1975 онд үзэгчдийн хүртээл болсон тус бүжгэн жүжиг 44 дэх жилдээ тайзнаа амилах гэж буй бөгөөд энэ сарын 8-нд ДБЭТ-ын тайзнаа тоглох юм. Тоглолтын тасалбар 10-30 мянган төгрөгийн үнэтэй. ■

### SNOW MELODY

Улсын филармониос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Snow Melody зургаа дахь жилдээ эгшиглэх гэж байна. Энэ сарын 27-нд Соёлын төв өргөөнд ганцхан удаа болох уг тоглолтод хуучны гадаад болон Монголын хамгийн шилдэг хөгжмүүд эгшиглэдэг онцлогтой. 120 минут үргэлжлэх тус тоглолтын тасалбар 20000, 40000 төгрөг аж. ■



### ЧИНГИСИЙН ЦОМ

Монголын тулааны шилдэг тамирчдын холбооноос зохион байгуулдаг “Чингисийн цом-2019” холимог тулааны тэмцээн энэ сарын 6-нд Бөхийн өргөөнд болно. Монгол туургатны гэх тодотголтой уг тулаанд Буриад, Тува, Халимаг, Өвөрмонгол, Монголын тулаанчдын халз тулааныг сонирхохыг үзвэл тасалбар нь 10000, 50000 төгрөгийн үнэтэй юм байна. ■

